



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-7</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>8-46</i>
<hr/>	
<i>1. Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>10-13</i>
<i>2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>13-14</i>
<i>3. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>14-20</i>
<i>4. Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурах, эрхийг хангах хүрээнд зохион байгуулсан Хяналтын сонсголын тайлан сонсох</i>	<i>20-30</i>
<i>5. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” Төрийн өмчит хувьцаат компанийн талаар тавьсан асуулгын хариуг сонсох</i>	<i>30-46</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Э.Батиугар, Б.Бейсен, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан;

Чөлөөтэй: Ж.Батжаргал, Л.Оюун-Эрдэнэ, Б.Саранчимэг;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд;

Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Нямбаатар, Н.Учрал;

Хоцорсон: С.Амарсайхан-25 минут, Ж.Батсуурь-48 минут, Ж.Бат-Эрдэнэ-1 цаг 25 минут, Х.Ганхуяг-1 цаг 25 минут, Ц.Даваасүрэн-23 минут, Л.Мөнхбаатар-21 минут, М.Оюунчимэг-1 цаг 25 минут, Д.Өнөрболор-24 минут, Ш.Раднаасэд-1 цаг 22 минут, Ц.Сэргэлэн-30 минут, Д.Цогтбаатар-1 цаг 23 минут, Б.Энх-Амгалан-38 минут, Ж.Эрдэнэбат-1 цаг 25 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Нэг.Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, Төсөлд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх иргэнд тавигдах шаардлага

4.1.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэн дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 7 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгоогүй байх;

4.1.2.нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байх;

4.1.3.төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхийг зөвшөөрч, хүсэлт гаргасан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	18
Бүгд:	47

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	19
Бүгд:	46

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ц.Цэрэнпунцаг нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	25
Бүгд:	51

51.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурах, эрхийг хангах хүрээнд зохион байгуулсан Хяналтын сонсголын тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, мөн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд, Салбарын хяналтын газрын дарга С.Сүнчин, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материал, үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Б.Буяннэмэх, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, мөн газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын Хорио цээрийн хэлтсийн дарга Г.Батмөнх, Стандарт, хэмжилзүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ууганбаяр, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал С.Өнөрсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурах, эрхийг хангах хүрээнд зохион байгуулсан Хяналтын сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал С.Өнөрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурах, эрхийг хангах хүрээнд зохион байгуулсан Хяналтын сонсголын тайланг сонслоо.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 25 минут үргэлжилж, 11 цаг 33 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 04 минутад эхлэв.

Тав.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” Төрийн өмчит хувьцаат компанийн талаар тавьсан асуулгын хариуг сонсох

Асуулгын хариулттай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Дугаржав, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, мөн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Саранцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Монголжингоо, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Асуулгын хариуг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, О.Цогтгэрэл, Б.Баттөмөр, С.Одонтуяа, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Дугаржав, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” Төрийн өмчит хувьцаат компанийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонслоо.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы урилгаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын парламентын гишүүн, тус улсын Ерөнхий сайдын Монголын асуудлаарх худалдааны элч Даниел Кавчински, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн залуучуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн урилгаар Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2004 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 1990 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Б.Жавхлан, Б.Баттөмөр нарын урилгаар Дархан-Уул аймгийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл, “Шихихутуг” хууль зүйн сургуулийн Бизнесийн эрх зүйн ангийн 2в ангийн оюутнууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 31 минут үргэлжилж, 73 гишүүнээс 60 гишүүн хүрэлцэн ирж, 82.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ

2023 оны 04 дүгээр сарын 14-ний
өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 08 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нийт 5 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутган төлөх тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг явуулна. Зарчмын зөрүүтэй 2 саналтай.

Хоёрдугаарт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Гуравдугаарт, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурах эрхийг хангах хүрээнд зохион байгуулсан Хяналтын сонсголын тайланг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн талаар тавьсан асуулгын хариуг сонсоно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу хэлэлцэхээр тогтсон эдгээр асуудлуудыг хойшлуулах, дарааллыг нь өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад саналаа 17 цагаас өмнө ирүүлнэ гэсэн дэгийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар, Бөхчулууны Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлсэн байна.

Ингээд Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ.

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн амар амгаланг айлтгая. Бид бол өөрсдийнхөө тухай өөрсөдтэй холбоотой хууль дээр их анхаардаг болжээ. Дахиж яаж сонгогдох вэ, Сонгуулийн хууль дээр л бид их цагаа зарцуулдаг болж. Харин өнөөдөр би дараалал өөрчлөх, асуудал шинээр яаралтай оруулж ирэх санал гаргаж байна. Тэр нь юу вэ гэвэл бид хойч үеийнхэндээ анхаарлаа сулруулмааргүй байна. Боловсролын тухай хууль 2021 оны 11 сард 3 жилийн өмнө орж ирсэн болж таарч байна шүү дээ. 21, 22, 23. Одоо 1 дүгээр ангид тэр үед орж байсан хүүхэд одоо 3 дугаар анги болчихсон. Боловсролын тухай асуудал дээр бид үнэхээр хойрго хандаж байна. Боловсролын багц хуулийг яагаад ингэж гацаагаад орж ирэхгүй байгаа юм бэ. 21 аймаг 9 дүүргээр Боловсролын тухай хуулийн хэлэлцүүлгийг явуулсан. Мөнхцэцэг даргатай боловсролын салбарын хамт олон энэ дээр Байнгын хороо ажилласан. Ц.Мөнхцэцэг, Ундрал гишүүн бид бас ажиллаж байсан. 21 аймаг мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвүүд, СӨБ-үүд, ЕБС-ээр ингээд орсон байгаа. Тэгэхээр Засгийн

газраас энэ Боловсролын багц хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн бариад ингэж удаж байгаа явдал бол ашиг сонирхлын зөрчилтэй байна. Улсын Их Хурлаар энийг хэлэлцүүлэхээс бас эмээж байна гэж би санаа зовж байна. Ингээд Боловсролын тухай хууль дотор бол миний дэмжиж байгаа, дэмжихгүй олон зүйлүүд байгаа. Өнөөдөр энийг би ярих гээгүй. Энийг яаралтай Их Хурлаар оруулж ирж хэлэлцүүлэх хэрэгтэй байна. Энэ саналыг Улсын Их Хурлын эрхэм гишүүд дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Хүүхэд бүрд амьдралын гараагаа ижил тэгш эхлүүлэх боловсролын алтан боломжийг бид өгөх нь Улсын Их Хурлын гишүүдийн амин үүрэг. Монгол шиг эрүүл мэнд, боловсролын салбараа базаар дээр гаргаад тавьчихсан, ашигийн хэрэгсэл болгоод тавьчихсан орон Монголоос өөр байхгүй дээ. Боловсролын салбар, эрүүл мэндийн салбар үндсэндээ боловсон хүчнээ алдаад дуусаж байна. Ийм гунигтай байдлыг бид мэдэхгүй юм шиг зөвхөн Сонгуулийн хуулиа хэлэлцээд байна гэдэг бол харамсалтай байна. Ингээд миний санал бол хэлэлцэх эсэх энэ Улсын Их Хурлаар яаралтай Боловсролын тухай багц хуулийг яаралтай оруулж ирээч гэдэг энэ саналыг гаргаж гишүүд дэмжинэ гэдэгт би итгэлтэй байна.

Г.Занданшатар: Боловсролын хууль дээр ажлын хэсэг ажиллах шаардлага бий болсон. Анхны хэлэлцүүлгээр Хүмүүнлэгийн боловсролын хуулийг салгасныг манай ажлын хэсгийн гишүүд эсэргүүцээд, даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцээд Хүмүүнлэгийн боловсролын тухай хуулийн ажлын хэсгийг шинээр байгуулж ажиллана.

Хоёрдугаарт нь Боловсролын тухай хуульд Боловсролын сайд, Боловсролын яам 2-ын чиг үүргийг салгаад Боловсролын сайдын эрхийг 26 эрх, үүргээр нэмэгдүүлсэн мөртөө яам нь эзэнгүй, боловсролын агентлагийг

шинээр байгуулж байгаа данхайсан бүтэцтэй гэх мэтчилэн маш их шүүмжлэл энэ боловсролын салбараас иргэний нийгмийн байгууллагуудаас ирсэн. Бас 1 том зөрчилтэй байгаа асуудал нь бол ашигийн төлөө ч байж болно, ашигийн бус ч байж болно, компани ч байж болно, төрийн бус байгууллага ч байж болно гээд 2 өнцөгтэй хийсэн нь хуулийн зөрчилтэй байдлыг бий болгоно гэж Улсын Их Хурлын Тамгын газраас эрх зүйн дүгнэлт гаргасан.

Ийм учраас ажлын хэсэг дээр орж саналуудаа хэлж, ажлын хэсгийн ахлагч Дамдинням дарга бол энэ дээр нэлээн сайн ажиллах хэрэгтэй байна гэсэн саналыг ирүүлсэн. Тэгээд ажлын хэсэг дээрээ сайн ярилцана. Хүмүүнлэгийн боловсролын хуулийн асуудлаар Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж, сэргээж ажиллаж байгаа. Ер нь дэлхийн түвшиний Монгол хүн, Монгол хүүхдийг бэлтгэх тийм боловсролын тогтолцоо хэрэгтэй байна гэж.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Өчигдөр сонгуулийн хуулиар жсоохон ярьсан. Иргэд хойтон болох сонгуулийн хууль яах вэ, хүүхдийн мөнгө, хөгшидийн тэтгэврийн талаараа шаардлага тавиач ээ гэж хэлж байна. Тэгэхээр хүүхдийн мөнгийг ялгавартай олгодог болсноос хойш аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн газраар дүүрэн өргөдөл. Нийгмийн хамгааллын яамаар дүүрэн өргөдөл. Тэрийг яаж шийдэж байна вэ гэх дээр Булгантуяа энэ манай тойргийн хүн юм байгаа юм. Энэний хүүхдийн мөнгийг нь өгчхөөч гээд. Тэгээд албан тушаалтан нь өгдөг. Тэгэнгүүт өө манай Ерөнхий сайдын нутгийн хүн ирчихсэн байна энэний хүүхдийн мөнгийг нь өгчхөөч гэдэг, манай генсекийн нутгийн хүн нь ирчихсэн байна. Тэрний мөнгийг нь өгчхөөч гээд ингээд л өгдөг. Энэ тэгээд нөгөө аймгийн дарга нар нь тэгээд л доошоо тэр нөгөө Хөдөлмөр, халамжийн газрынхаа дарга нарт энэ

хүүхдийн мөнгийг нь өгөөрэй. Манай намыг дэмждэг гээд л ийм байдлаар л өргөдөлд хариу өгдөг ийм болчхоод байна шүү дээ. Тэгээд энэ яагаад ялгаруулаад байгаа юм бэ. Тэгээд үлдсэн нь хөөцөлдөөгүй нь ингээд хоосон хоцордог ийм байж болохгүй шүү дээ. Тийм учраас энэ хүүхдийн мөнгийг хүүхэд болгонд өгөх тухай асуудлыг Засгийн газар яаралтай оруулж ирж, шийдэх ёстой. Энийг Их Хурал шийдэх ёстой. Тэгэхгүй бол энэ хүүхдүүдийг ингээж ялгаруулдаг байдал хэрээс хэтэрч байна шүү дээ. Угаалгын машинтай, хөргөгчтэй гээд хүүхдийн мөнгөнөөс хасдаг. Хаашаа байшинтай гээд хүүхдийн мөнгөнөөс хасдаг ийм юм гэж юу байдаг юм бэ.

Хоёрдугаарт нь энэ Нийгмийн даатгалын багц хуулийг оруулж ирсэн бас дахиад л нөгөө Боловсролын хуулийн араас орох нь. 3 жилийн дараа хэлэлцэх нь л дээ. Тэгээд энэ Анужин дарга та хөдөөгүүр ингээд уулзалт хийгээд яваад байна. Тэр нь наадах багц хуулийнхаа ажлын хэсгийг яаралтай ажилд оруул. Тэр шинэ сайдыгаа хурдан дуудаад энэ хууль дээрээ дахиж тодорхой саналууд гаргахгүй бол Аюурсайхан сайд чинь баахан юм оруулаад ирчихсэн. Тэрийг нь нийгмийн даатгалын сан чинь дийлэхгүй ийм юм руу явчихсан байгаа шүү дээ. Тэрийгээ цэгцлээд ялангуяа 7 жилийг 5 жил болгох, тэрийг нөхөн бодох энэ 2 хуулийн төслийг хамтатгаж оруулж ирэх ийм шаардлагыг танаас Байнгын хорооны даргаас шаардаж байна. Хөдөөгөөр яваад уулзалт хийгээд байгаа. Би ойлгож байгаа. Тэгэхдээ энд хамгийн гол нь хууль батлах нь чухал байхгүй юу даа. Хүмүүс тэртээ тэргүй Нийгмийн даатгалын багц хуулиар олон асуудлыг хүлээж байгаа. Тэр хүлээлт дээр хурдан ажиллах хэрэгтэй байна. Тэр сайд нь ажлаа хийх хэрэгтэй байна. Энд тэндхийн жижиг сажиг томилгоонд оролгүй тэр нийт ард түмний асуудлыг шийдэх Нийгмийн даатгалын багц хуулийг яаралтай оруулж ирж, хэлэлцүүлэх энэ асуудлаа хурдлаач ээ.

Тэгээд хамгийн сүүлд нь нөгөө Занданишатар даргыгаа зад шүүмжлээч ээ гэж намайг хэлж байна. Энэ микрофоныхоо ингээд удирддаг хүнтэйгээ хамаагүй бас шүүмжилж болдоггүй юм. Уучлаарай ард түмэн.

Г.Занданишатар: Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоогүй юм байна. Хэлэлцэх асуудлын дараалал нэмэх асуудал биш байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Цэвэгдоржийн Туваан гишүүн нарын 10 гишүүн. Сандагийн Бямбацогт, Жигжидийн Батжаргал, Гочоогийн Ганболд нарын 10 гишүүн санаачилсан хууль байгаа.

Ингээд төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын хорооны танилцуулгыг Цэндийн Сандаг-Очир гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, А.Адъяасүрэн, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Н.Ганибал, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаатар нараас 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явууллаа.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулах чиглэл өгсний дагуу Байнгын хорооны 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 2 санал боловсруулсныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу санал хураалт явуулж, шийдвэрлэсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл Байнгын хорооны танилцуулгыг зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Хаянгаагийн Болорчулуун гишүүнээр тасаллаа. Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нар үр тариа, ноос, сүүний урамшуулал гэх мэтчилэнд урамшууллаас нь нийгмийн даатгалын шимтгэл авна гэсэн хууль гарч байна. Авч болно, үгүй ч байж болно гэсэн. Тэгэхээр аливаа хууль бол тодорхой байх ёстой. За бол за, үгүй бол үгүй. Гэтэл ийм бөөрөнхий байдлаар хүмүүс тэнд урамшууллаас төлж болно, төлөхгүй ч байсан болно гэсэн ийм байдлаар хууль орж ирж байгаа нь өөрөө их бүрхэг байгаа юм.

Хоёрдугаарт энэ хууль дээр бол малчид, тариаланч тэр болгон бэлэн мөнгөгүй байдаг энэ урамшууллаас нийгмийн даатгал төлөх нь нийгмийн даатгалын тасрахгүй байх энэ тэр шалтгаан болно гэж байна. Ер нь 1960 оноос хойших төрсөн хүмүүс бүгд сан бүрдэж байгаа шүү дээ. Тэр тасрах, тасрахгүй асуудал огт хамаагүй. Тэгэхээр ийм бөөрөнхий үзэл бодолтой ийм хуулийг оруулах нь учир дутагдалтай гэж үзэж байна.

Г.Занданишатар: Байнгын хороо Сандаг-Очир гишүүн хариулах уу. Цэндийн Сандаг-Очир гишүүн, ажлын хэсэг хариулъя.

Ц.Сандаг-Очир: Харин тийм ээ, бас салбарын сайд, Засгийн газрын гишүүн бас энэ хуулийг ингээж үгүйсгэж байгаад харамсаж байна. Яагаад гэхээр хөдөө аж ахуйн салбарыг хариуцдаг салбарын сайд маань 305,000 нийт малчид. Малчид маань өөрсдөө өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 10 орчим хувийг үйлдвэрлэж байгаа. Нийт ажиллагсдын ажиллах хүчний 30 орчим хувийг бүрдүүлж байгаа. Гэтэл эдгээр малчид маань өнөөдөр Эрүүл мэндийн

даатгалын шимтгэл төлөхгүйгээс болоод нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүйгээсээ болоод сөрөг үзэгдлүүд асар их гарч байгаа. Энэ нь эргээд өөрсдөө малчдын газар тариалан эрхлэгчдийн нийгмийн даатгалын үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ авах тэр бололцоо, боломжийг өөрсдөд нь олгож байгаа юм. Хэдийгээр даатгалын шимтгэл төлөх нь сайн дурын боловч бас хүчээр шууд авч болохгүй байгаа юм аа. Иргэнд өөрт нь бас сонголтыг нь үлдээж байгаа юм. Тэр өөрсдийнх нь тушаасан сүүний хэмжээ мөн арьс, ширнийх нь хэмжээ, тооноос хамаараад бас янз бүрийн тушаалтны хэмжээ бол янз бүр байгаа. Тийм учраас өнөөдөр нэгэнт бодит байдал дээр ийм үзэгдэл байгаа учраас нөгөө талаас нийгмийн даатгалын сангийн орлого, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бас тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх ийм бололцоо боломж энэ хуулийн хүрээнд бас үүснэ. Ингээд эргээд тэтгэвэрт гарлаа гэхэд малчин хүн нийгмийн даатгалын шимтгэлээ төлж чадаагүйгээсээ болж тэтгэврээ тогтоолгож чадахгүй асуудал үүсэж байна. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг цаг хугацаандаа төлөөгүйгээс болоод эрүүл мэндийн үйлчилгээгээ цаг хугацаандаа авч чадахгүй байдал үүсэж байна. Хэдэн мянгаараа. Тийм учраас эдийн засгийн хямрал, эдийн засгийн дарамтаас болоод олон жил хуримтлагдаж төлөөгүй болоод ийм үйлчилгээгээ авч чадахгүй байгаа учраас цаг тухайд нь хавар, намартаа энэ орлого олдог үед нь өөрсдийнх нь сонголтоор хүлээн зөвшөөрвөл энэ төрөөс олгож байгаа урамшуулалд нь суутгаад авчихдаг байя л гэдэг ийм л хуулийн үзэл баримтлал шүү дээ. Тэрнээс төрөөс өөр нэг төсөв санхүүгийн дэмжлэг, урамшуулал өгч байгаа юм ерөөсөө байхгүй. Малчин хүн өөрийнхөө малынхаа арьс ширийг тушаасан тэрнийхээ урамшуулалдаа буцаагаад эрүүл мэндийнхээ юм уу, нийгмийн даатгалынхаа аль аль нь хүрэлцээтэй бол аль алиныг нь 100%

төлөөд явчихад хэн хэндээ ашигтай ийм хуулийн төсөл байгаа шүү гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нийгмийн бодлогын байнгын хороо
дэмжсэн санал

“4 дүгээр зүйл.Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх иргэнд тавигдах шаардлага

4.1.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэн дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 7 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгоогүй байх;

4.1.2.нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байх;

4.1.3.төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхийг зөвшөөрч, хүсэлт гаргасан байх.” Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. 61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт. 58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалтын дүнг танилцуулсан. Зарчмын зөрүүтэй

саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төрөөс олгох урамишууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

10.28 цаг.

Болорчулуун гишүүн ээ, энэ бол хөдөө аж ахуй, малчдад хэрэгтэй хууль байхгүй юу. Тэгш шударга ёсны тухай хууль ч гэсэн.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 заалтад заасны

дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төслийг бэлтгэсэн болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцсэн, хуулийн төслийг эцэслэн баталж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Тэгэхдээ ажлын хэсэг ажилласан хүмүүсийг танилцуулчихъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Батжаргалын Цогтсаран. Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Базаррагчаагийн Уранчимэг байна.

Гишүүд асуулт, хариулт алга байна. Ингээд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах

бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ корпорацийг тэр шинэ компани байгуулахгүй гээд л санаачилгууд гарсан. Энийг харин хараат бус мэргэжлийн удирдлагатай болгоход л их сайн анхаарах ёстой юм байгаа юм. Цогтсаран дарга энэ тэр анхаарах хэрэгтэй.

Ингээд дараагийн асуудалд орно. Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

10.31 цаг.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан танилцуулна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар хийх үед Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг төсөл санаачлагчид буцаасантай холбоотойгоор холбогдох тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хороо

нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь заалт, хэсэгт заасныг үндэслэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хөдөө аж ахуйг дэмжих санг татан буулгасантай холбогдуулан тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр төлбөр, авлагыг “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүрэн шилжүүлж, өр авлагыг ангилж, улсын төсөвт төлөх өр төлбөрийг 2024 онд багтаан төлж барагдуулах, компанийн засаглалыг, төр-хувийн хэвшлийн түншилэлийг хөгжүүлэх хүрээнд газар тариалан, мал аж ахуй эрхлэгч болон мэргэжлийн холбоодын оролцоог хангасан олон нийтэд нээлттэй компани болох, компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн хуулийн этгээдтэй өрсөлдөхгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгах нь зүйтэй гэж тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Хөдөө аж ахуйг дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй өр, хөрөнгө төлбөр, авлагын талаар асуулт асууж хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар төр-хувийн хэвшлийн түншилэлийн хүрээнд газар тариалан, мал аж ахуй эрхлэгчид болон мэргэжлийн холбоодын оролцоог хангах, олон нийтэд

нээлттэй компани болгох ажлын явц болон тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь зүйтэй гэсэн санал гаргалаа.

Байнгын хорооноос хуралдааны тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Гишүүд суудалдаа суугаарай. Зочид танилцуулъя.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын парламентын гишүүн, тус улсын ерөнхий сайдын Монголын асуудлаарх худалдааны элч Даниел Кавчинский Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайханы урилгаар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд парламентын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхан үр бүтээл, өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа. Гишүүд суудалдаа суугаарай. Доржханд гишүүнд суугаарай. Гадна,

дотнын зочид харж байхад. Адьшаа гишүүн тойруулгаа эхэлчихсэн бол суудалдаа суугаарай. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух гишүүд Цэрэнпунцаг гишүүнээр тасалсан. Тилеуханы Аубакир гишүүн асуулт асууна.

Т.Аубакир: Баярлалаа. Ингээд үндсэндээ Хөдөө аж ахуйг дэмжих сан маань бас ХХК болоод энэ олон нийтийн компани болох чиглэл рүүгээ явж байна л даа. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Монголын газар тариалан, хүнсний хангамжид үзүүлсэн нөлөө маш өндөр. 2008 оны Атрын аян зарласнаас хойш үндсэндээ 1991 оноос 2008 он хүртэл тасалдчихсан байсан дотоодын улаан буудайн хангамжийн асуудлыг бас цэгцэд нь “Атрын 3” дугаар аянтай зэрэгцээд бас цэгцэд оруулсан сангийн I байсан юм л даа. Яах вэ мэдээжийн хэрэг хүнсний ногоо эрхлэгчид, тариалан эрхлэгчид, мал аж ахуй эрхлэгчид хүнд хэцүү цаг агаарын нөхцөлтэй, эдийн засгийн хүнд хэцүү нөхцөлд ганцхан ханддаг сан нь Хөдөө аж ахуйг дэмжих сан байсан юм. Хандахаас өөр арга байхгүй. Тухайн сан дээрээс зээл аваад, үйл ажиллагаагаа явуулаад Монгол Улсын хүнсний хангамжид тодорхой хэмжээний нөлөө үзүүлээд явж байсан, зээл авсан хүн болгоныг бас ялтан мэтээр харагдуулж бол болохгүй. Одоо энэ бол Хөдөө аж ахуйг дэмжих сан дээрээс өртэй аж ахуйн нэгжүүдийг зарласан байна шүү дээ. Зээл авсан хүн болгон бол ялтан биш шүү дээ. Зээлээ зохих хугацаанд нь журмын дагуу төлөөд явж байгаа аж ахуйн нэгжүүд бий. Одоо сүүлийн үед I тийм юм ажиглагдаад байгаа юм. Жишээлбэл Хөгжлийн банкны асуудал байж байна. Зээл авсан хүн болгоныг л ялтан мэтээр харагдуулаад. Энэ чинь Монгол Ардын нам засаг барьснаасаа хойш хаашаа юм тэгээд зээл авсан хүн болгоныг ялтан болгож зарлаад, Хөдөө аж ахуйг дэмжих сангаас зээл аваад трактор техник, хор бордоо, шатахуун хөнгөлөлттэй аваад Монгол Улсын Монголын ард түмнийг талх, тариатай

нь байлгасан нь ял болж хувирах нь уу. Тийм учраас энэ дээрээ бас жоохон хууль хүчний байгууллага гэдэг ч юм уу бас жоохон учиртай хандмаар байгаа юм. Сүүлийн үед энэ чинь 1 л ийм байдал бий болчихлоо шүү дээ. Яг үүнтэй адилхан энэ Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Монгол Улсын газар тариалан, хүнсний хангамжид нийлүүлсэн хувь нөлөө бол өндөр байсан. Үүнтэй холбоотой шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд зарим төрийн өмчит компаниудыг олон нийтийн болгоё. Засаглалыг нь сайжруулья гэж байгаа явдлыг бол дэмжиж байгаа юм. Тийм учраас үүний өмнөх анхны хэлэлцүүлэг дээр миний оруулсан бас 2, 3 санал энэ дээр орсон байна.

Нэгдүгээрт тухайн Хөдөө аж ахуйг дэмжих сан маань ХХК болоод ижил төрлийн бизнес эрхлэгчидтэйгээ өрсөлдөөд, боож унагаагаад байж бас болохгүй. Техник нийлүүлдэг аж ахуй нэгж, хувь хүмүүс бий. Хор бордоо грефцид нийлүүлдэг хүмүүс бий. Запаас сэлбэг нийлүүлдэг, хүлэмж нийлүүлдэг хүмүүс бий. Эд нартайгаа өрсөлдөхгүй байхын тулд энэ ХХК-ийн дүрэм дээр одоохондоо ижил төрлийн бизнес эрхэлдэг хувийн хэвшилүүдтэйгээ өрсөлдөж болохгүй ээ гэж. Мэдээжийн хэрэг олон нийтийн болно. Олон нийтийн болгоход нь яг тэр ижил төрлийн бизнес эрхлэгчдэд нь энэ хувьцааг эхэлж санал болгох зохион байгуулалтыг манай ажлын хэсгийнхэн олж зохион байгуулах хэрэгтэй. Ижил төрлийн бизнест техник тоног төхөөрөмж нийлүүлдэг, шатахуун хор бордоо грефцид нийлүүлдэг энэ хүмүүсийнхээ бизнест садаа болгохгүйн тулд тэр хүмүүсийг нь энэ хувьцааг худалдаж авахад нь татан оролцуулах энэ нөхцөл байдлыг нь бий болгох хэрэгтэй. Олон нийтийн болтлоо дүрэмдээ өөрчлөлт оруулаад тэд нартайгаа одоохондоо өрсөлдөж болохгүй. Бид нар хэрэгтэй үед нь хэрэглэхээд, хэрэггүй болонгуут л нь ингээд хаяад явдаг ийм цамаан зантай байж болохгүй л дээ. Хөдөө аж ахуйн

сангийн Монгол Улсын газар тариалан, хүнсний хангамжид нийлүүлсэн хувь нөлөө бол өндөр. Бид нар бас эргээд хэцүү хүнд байсан үеэ санах хэрэгтэй. 1991 оноос үндсэндээ 2012 он хүртэл энэ цаг агаарын дулааралтай холбоотой Монгол Улсад бид нар чинь хөри айлуудаасаа шанага будаа гуйгаад явж байсан үе саяхан шүү дээ. Одоо л сүүлийн үед жоохон тааламжтай уур амьсгалтай болоод хангамжийн асуудал явж байгаа болохоос биш. Тийм учраас энэ асуудлыг бол дэмжиж байгаа. Саяын энэ миний хэлсэн энэ 3, 4, 2 дээр байгаа саналуудыг бас хэрэгжүүлэх тал дээр ажлын хэсэг ажиллаарай гэж захъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Төсвийн байнгын хороон дарга Ганзоригийн Тэмүүлэн асуултад хариулна.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай холбогдуулаад энэ асуудлыг хэлэлцэх эсэх асуудал дээр ч тэр анхны хэлэлцүүлэг дээр ч тэр ер нь зүгээр Улсын Их Хурал дээрээс гарсан гол үндсэн санал гол гишүүдийн хэлсэн асуудлууд бол энэ Хөдөө аж ахуйг дэмжих санг татан буулгаж цаашид корпорац болгохтой холбоотой энэ компанийг ил тод, нээлттэй хувьцаат компани болгох асуудал байсан 1 дүгээр асуудал.

Хоёрдугаарт сая Аубакир гишүүний саналаар бас анхны хэлэлцүүлэг дээр хэлсэн гол үндсэн концепцын асуудал бол ерөөсөө энэ компанийнхаа дүрэм дээр нь өөрчлөлт оруулаач. Залгуулаад энэ компани маань хувийн хэвшилтэйгээ өрсөлддөг байж болохгүй. Хувийн хэвшлийнхээ хийж байгаа ижил төрлийн бизнесийн үйл ажиллагааг булаацалдаг байж болохгүй. Энэ дээр тодорхой хязгаарлалтын асуудлуудыг дүрэм дээр нь тусгаж өгч, хувийн хэвшлийн хуулийн этгээдтэй өрсөлдөхгүй байх энэ хууль эрх зүйн орчны зохицуулалтыг энэ дээр тусгаж өгөөч гэдэг асуудлыг тавьсан.

Тэгээд гишүүдээс гарсан саналын дагуу, мөн дээрээс нь өр төлбөртэй холбоотой асуудал байгаа. 1 талдаа энэ тусгай сан татан буюгдаж байгаа бол одоог хүртэлх хуримтлагдсан байгаа өр төлбөрүүдийг энэ компани бүрэн шилжүүлэх, цаашид тодорхой заасан хугацаанд төсөвт барагдуулах, төсөвт төвлөрүүлэх энэ арга хэмжээг ав гэсэн энэ асуудлууд байсан.

Тэгэхээр эдгээр асуудлуудын үндсэн дээр Төсвийн байнгын хорооноос хэлэлцээд ерөөсөө Улсын Их Хурлаас энэ хууль баталсантай холбогдуулаад Засгийн газарт чиглэл өгсөн, үүрэг, даалгавар өгсөн энэ тогтоолыг батлах ёстой юм байна гээд энэ 3 асуудлыг тусгаад ингээд тогтоолын төслийг та бүхэнд оруулж ирж байна. Тэгэхээр эдгээр тогтоолын дагуу бид нар тодорхой хугацаатай үүрэг даалгавруудыг өгч байгаа. Цаашид тэр дундаа протоколоор бид нар бас энэ олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох асуудлыг явцыг нь танилцуул. Тэр дундаа энэ хаврын чуулган дуусахаас өмнө буюу 7 сараас өмнө үр дүн, хэрэгжилт, биелэлтийн явцын тайланг бид нарт Төсвийн байнгын хороонд танилцуул гэсэн чиглэлийг бас өгсөн байгаад байгаа юм.

Г.Занданишатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Миний асуух гэж байгаа асуултад Тэмүүлэн дарга сая бас ерөнхийдөө хагас хугас хариулчихлаа. Хөдөө аж ахуйн корпорац гэдэг юм байгуулах гээд компани байгуулах нь ээ. Манай Байнгын хороон дээр Цогтбаатар гишүүний өргөн барьсан, Цогтгэрэл гишүүний өргөн барьсан 2 ийм Их Хурлын тогтоолын төсөл явж байгаа. Ажлын хэсэг гарчихсан, Батлут гишүүн ахалж байгаа. Нэгтгээд эд нар бол хамгийн гол агуулга санаа нь бол цаашидаа энэ төрийн өмчтэй компани байгуулахаа больё гэсэн ийм агуулгатай юм байгаа юм. Тэгэхээр

энэ Их Хурлын тогтоолын төслийг ингээд харахаар Хөдөө аж ахуйн корпорац гэдэг компани байгуулахыг зөвшөөрөөд, гэхдээ байгуулахдаа энэ тогтоолынхоо төслөөр ийм ийм үйл ажиллагаа явуул, ингэж дүрмээ өөрчил гээд ийм чиглэл өгч байгаа юм байна гэж ойлгоод байна. Тэгэхдээ Тэмүүлэн дарга аа энэ чинь хоорондоо зөрчилдөхгүй ийм юмнууд байх юм. Жишээлбэл хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй компани гэж ямар компанийг хэлдэг юм бэ. Компани гэдэг бол ашигийн төлөө байгууллага. Ашиг олдог үйл ажиллагаа явуулж байвал энэ компани гэж бид нар үзнэ. Тэгэхээр өрсөлддөггүй мөртөө ашиг олдог гэхээр юу гэсэн үг юм. Тэр монопол эрх өгөх юм уу, тэр рүү нь хувийн хэвшлийнхэн орохгүй. Тэгээд өрсөлддөггүй. Үгүй ээ, энэ чинь жинхэнэ ялзарсан юм болох нь байна шүү дээ. Ийм чиглэл өгч болохгүй ээ Тэмүүлэн дарга аа. Энийгээ тодорхой болгох хэрэгтэй. Өрсөлдөхгүй жишээлбэл нээлттэй компани болгоно гэхихсэн байгаа юм. Тэгээд өрсөлддөггүй, хувийн хэвшилтэй өрсөлддөггүй нээлттэй компани чинь тэгээд компанид нь орж байгаа тэр компанийнх нь хувь эзэмшигчид гэдэг юм уу эзэд нь хэн болж таарах юм бэ. Энэ чинь нэг хэсэг ийм картель үүсгэх гээд байгаа юм уу. Энэ болохгүй. Энэ одоо бид нарын явж байгаа зүг чиг. Бид нар өнөөдөр төсөв яриад байж байгаа. Төсөвтөө шинэчлэл хийе гээд Тэмүүлэн дарга аа. Энэ төсөв дээр шинэчлэл хийх 1 том шалтгаан бол энэ төрийн өмчтэй компаниуд эд нараас ужгирч гарч ирсэн, эд нарын угшилтай өр шир, энэ Засгийн газрын өр шир явж байгаа юм энэ бүгд энэ компаниудаас чинь л ирж энэ дээр наалдаж, тэгээд татвар төлөгчид ард түмэн татвараар эсвэл инфляцаар энийг нь төлдөг. Энэ дээр л 1 ачаа нэмэх юм болох нь байна шүү дээ. Тэгээд дээрээс нь одоо энэ ямар дүрэм гэж байх юм бэ. Компани бол хоёрхон компани байгаа. Нээлттэй компани, хаалттай. Тэгээд ХХК гээд. Энэ чинь бол хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж байгаа юм. ХХК байх нь байна шүү дээ.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бол ямар ч хяналтгүй компани. Тэгээд нийлдэг энэ хооронд чинь энэ бүх тавьсан шаардлагууд чинь бүгд хоорондоо зөрчилтэй байна. Ийм компани байгуулж болохгүй. Энэ тогтоолын төслөө ингээд татаад авчхаж болохгүй юм уу. Энэ хэлэлцүүлгээс. Ийм үед бид нар энэ төсвийн шинэчлэл хүртэл ярьж байна. Цаашидаа энэ эдийн засагт хувийн хэвилийнхэн тэр өрсөлддөг тэр үр ашигтай, эдийн засгийн нөөц бололцоог үр ашигтай ашигладаг, үр өгөөжөө өгдөг, авсан өрөө төлдөг хувийн хэвилийнхнийг эдийн засагтаа оролцуулъя, оролцоог нь нэмье гээд энэ төр-хувийн хэвилийн түншлэлийн хууль хүртэл гараад явж байгаа. Тэгэхэд хажуугаар нь ийм юм оруулж ирдгийг оруулж ирж болохгүй ээ гэж бодож байна. Ийм л байна даа.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултад хариулна.

Г.Тэмүүлэн: Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Цэрэнпунцаг гишүүн ээ, та бас энийг зөв ойлгоорой. Засгийн газраас орж ирсэн хуулийнх нь төсөл нь болохоор тусгай санг татан буулгаад, төрийн өмчийн компани байгуулъя гэсэн зүйл орж ирж байгаа юм. Байнгын хорооноос бид нар санаачилж байгаа энэ тогтоолын төсөл бол ерөөсөө зарчмын хувьд таны саналтай 1 байгаа. Төрийн өмчийн компани байх ёсгүй гэдэг асуудал байгаа. Хэрэв бид нар энэ Байнгын хорооны тогтоолоо татаад авах юм бол энэ чинь цэвэр төрийн өмчийн компани

болно гэсэн үг. Бид нар энэ тогтоолоор чиглэл өгч байгаа зүйл маань болохоор ерөөсөө энэ төрийн өмчийн компани байгуулах гэж байгаа бол энэ чинь ХК байх ёстой юм. Тэр дундаа малчид, тариаланчид болоод газар тариалан эрхэлж байгаа мэргэжлийн холбоонуудын оролцоог хангасан, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болго гэдэг асуудал тавьж байгаа. Одоо энэ хаврын чуулган дуусахаас өмнө бид нар өөр энэ ажлынх нь явцыг танилцаад, Байнгын хороо дээр хэрэглэгчдийг нь оруулж ирээд та бүхэнд танилцуулна гэж бодож байгаа. Тэгэхээр энэ тогтоол өөрөө бид нарт хэрэгтэй. Энэ бол ерөөсөө анх хэлэлцэх эсэх болоод анхны хэлэлцүүлэг дээр гишүүдээс гарсан саналын дагуу бүх таны хэлж байгаа болгоомжлол болоод бусад өр ширтэй холбоотой асуудлууд, энэ бид бүхний үндсэн суурь зарчмын асуудлуудыг бүгдийг нь тусгасан л ийм тогтоол байгаад байгаа юм. Тэгэхээр Засгийн газар бол энэ сангаа татан буулгая, үйл ажиллагаа нь доголдчихсон цаашид санхүүгийн хувьд энэ үйл ажиллагаа нь доголдолтой учраас энийг бид нар хэвийн явж байх боломжгүй учраас энэ сангаа татан буулгая. Харин энэ газар тариалантай холбоотой, агро технологийн үйл ажиллагаатай холбоотой, цаг хугацаа шаардсан энэ ажлуудыг одоогоор цаашид үр ашигтай ажиллуулах үүднээс төрийн өмчийн компани гээд байгаа юм. Зарчмын хувьд тэр байж болно. Гэхдээ төрийн өмчийн компани гэдэг асуудалтай концептууд бид нар санал нийлэхгүй байгаа. Төсвийн байнгын хороо дээр ч энэ асуудлыг ярьсан. Энэ үндсэн дээр бид нар харин үнэхээр та бүхэн компани байгуулах гээд байгаа бол үндсэн суурь зарчмаа баримтлаад ХК болгооч, нээлттэй компани болгох хугацаатай үүрэг даалгавар өгч байна л гэдэг энэ асуудлыг тавьж байгаа юм.

Дээр нь ер нь тодорхойгүй байсан хэд хэдэн асуудлуудыг бас энэ дээр тодорхой болгож өгсөн. Өр шир бүх

асуудлуудыг бүрэн ийш нь шилжүүл. Дээрээс нь төсөвт буцаагаад заасан хугацаанд нь төлүүлэх асуудлыг тавь. Саяын сүүлийн таны асуусан асуулт бол ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн хуулийн этгээдтэй өрсөлдөхгүй байх гэдэг чинь юу гэж байгаа юм бэ гэдэг асуудлыг тавьж байгаа. Тэгэхээр одоо орж ирсэн энэ компани угаасаа байгуулагдчихсан юм байна. Засгийн газар дээрээ 2021 оныхоо 394 дүгээр тогтоолоороо энэ шийдвэрээ гаргачихсан байгаад байгаа. Дээрээс нь энэ дүрэм дээрээ бол тодорхой энэ хувийн хэвшилтэй өрсөлдөхүйц хэмжээний ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр гэдэг юм уу, хувийн хэвшлийнхний хийх боломжтой ажлуудыг хүртэл дүрэм дээр тусгачихсан байгаад байгаа юм. Тэгэхээр үнэхээр энэ цаашидаа ямар нэгэн байдлаар ХК гэдэг юм уу, энэ чиглэлийн үйл ажиллагааг компани эрхлэх юм бол энэ нэг талдаа төрийн өмчийн компани хэсэг хугацаанд байх гээд байна шүү дээ. ХК болох шилжилтийн энэ хугацаанд. Энэ хугацаандаа ч гэсэн хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх энэ зарчмуудаа гаргаж ирээд тодорхой болгооч, дүрэм дээр заасан энэ асуудлуудаа өөрчлөөч, хувийн хэвшил хийдэг орон зай руу битгий булааж орооч ээ л гэдэг энэ асуудлуудыг тодорхой болгож зааж өгсөн байгаад байгаа юм. Тэгэхээр энэ тогтоол маань зайлиггүй шаардлагатай шүү. Энэ бол гишүүдээс гарсан, олон нийтээс болгоомжилж байсан бүх асуудлуудыг ингээд тодорхой заагаа, зааглаад хязгаарлаад өгсөн байгаа л гэдгийг танд хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: Нэргэсэн хойно нь л хашираад байна л даа. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар компани болгоно гээд хуулийг нь баталчихсан. Энэ тогтоол чинь харин тэр нээлттэй болгох, хяналттай байлгах, компани байгуулах хуулиа баталчихсан. Өмнө нь хэлээд л байсан шүү дээ. Одоо компаниа бол илүү яаж зах зээлийн зарчимтай, үр ашигтай, хараат бус ажиллуулах вэ

гэсэн агуулгатай тогтоол дагалдуулж батлах гээд байна шүү дээ. Цэрэнпунцаг гишүүн тодруулах уу. Цэрэндамбын Цэрэнпунцаг гишүүн тодруулж асууя.

Ц.Цэрэнпунцаг: Үгүй ээ энэ асуудал манай Байнгын хороогоор орж ирсэнгүй л дээ. Төсвийн байнгын хороогоор яваад, Хөдөө аж ахуйн яам нь оруулж ирсэн юм байна. Энэ ажлын хэсэг энд сууж байна. Тэгээд энэ компани байгуулах дуртай, төрийн өмчтэй компани байгуулах дур хүсэл ийм л их байгаа байхгүй юу. Тэгээд энийг чинь ард түмэн юу гэж ярих юм. Энэ тэгвэл тэр төрийн тусгай сангийн хууль эд нар дээрээ энэ нэмэлт, өөрчлөлт оруулаад цаашидаа ийм юмыг зогсоомоор байгаа юм. Энэ Засгаас энийгээ тэр хуульдаа өөрчлөлт оруулах энэ төслөө давхар оруулаад ирээч. Энэ сангаа татан буулгаад нөгөө талдаа гарцаа дахиж цаашидаа ийм сан байгуулах биш. Энэ сан гэдэг чинь одоо ер нь зүгээр ийм жижиг гөлөг байсан юмыг л бүр там олон толгойтой мангас болгож л оруулж ирж байгаа юм байна л даа. Корпорац гээд юун сүртэй нэртэй юм бэ.

Г.Занданшатар: ЖДҮ сан энэ тэр гээд олон сангууд чинь бас ийм. Одоо санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны саналаар тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал гаргасан. Энэ горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Ингээд Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. 26 гишүүн дэмжиж 51 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

10.55 цаг.

Дараагийн асуудалд оръё. Энэ асуудлын дараа даргын дэргэдэх зөвлөл хуралдана шүү. Байнгын хороодын дарга нар, Тэмүүлэн дарга, Цэрэнпунцаг дарга нар анхаарч байгаарай.

**Дотоод орчны агаарын
бохирдолтой холбоотой хууль
тогтоомжийн хэрэгжилтийг
хангуулах, хүүхдийн эрүүл, аюулгүй
орчинд амьдрах, сурах, эрхийг хангах
хүрээнд зохион байгуулсан Хяналтын
сонсголын тайлан сонсох**

Тайланг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурах эрхийг хангах хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Б.Баярсайхан, Х.Баделхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Ч.Ундрэм, Д.Цогтбаатар, Ж.Чинбүрэн, Д.Сарангэрэл нарын гишүүдээс хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой Хяналтын сонсгол явуулах хүсэлтийг хүргүүлсний дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийг баримтлан нийтийн сонсгол зохион

байгуулж, сонсголын тайланг Байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаар сонссон болно.

Хяналтын сонсголоор цэцэрлэг, сургууль, эмнэлгийн барилгын дотоод орчны агаарын чанарын үнэлгээ, чанар, стандартын шаардлага хангаагүй барилгын материалын хүний биед үзүүлэх сөрөг нөлөөлөл, барилгын дотор орчны агаарын чанарын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, улсын хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүргийн хүрээнд барилгын материалд тавьж байгаа хяналтын талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл сонсож Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсан бөгөөд сонсголд урьдчилсан бүртгүүлсэн оролцогчид саналаа хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар сонсголын тайланг сонсох үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа дотоод орчны агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч байгаа арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен цэцэрлэг, сургуулийн хана, шалны будгийн шинжилгээг ямар лабораторид хийж байгаа, шинжилгээний тоног төхөөрөмжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын Агаарын бохирдлыг бууруулах дэд хорооноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут дотоод орчны агаарын чанар нь тухайн барилгыг барихад ашигласан барилгын материалаас хамааралтай эсэх судалгаа хийгдсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авахдаа Улсын комиссоос зохих шалгууруудыг бүрэн хангасан буюу салхивч агааржуулалтын систем тавих шаардлагуудыг хангасан эсэхийг баримтлан хүлээн авч байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн сонсгол даргалагч Ч.Ундрам дотоод орчны агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурах эрхийг хангах хүрээнд Хяналтын сонсгол зохион байгуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг дараа нь танилцуулъя. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү. Асуулт байхгүй юу. Ажлын хэсгийн гишүүдийг ямар ч байсан танилцуулчихъя.

Барилга, хот байгуулалтын дэд сайд Золбоо, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганболдын Ганбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Төгсдэлгэр нар байна. Асуулт, санал алга байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүнийг нэмлээ. Булгантуяа гишүүн, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 2-ын карт уншигдаагүй юм уу. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ их чухал сонсгол зохион байгуулжээ. Би тэгээд энэ сонсголын хүрээнд та бүхэн маань энэ Биеийн тамирын сургууль гээд байж байгаа. Энийг та бүхэн маань үзэв үү. Энэ Биеийн тамир спортын ордон маань их өвгөрсөн. Насжилт их

өндөртэй. 1958 онд ашиглалтад орсон. Хятадын ард түмний тусламжаар баригдсан ийм ордон шүү дээ. Тэгээд энэ насжилт өндөртэй холбоотойгоор 2 удаа мэргэжлийн хяналт холбогдох байгууллагууд нь энд үйл ажиллагаа явуулж болохгүй гээд ийм шийдвэр, тогтоол гарчихсан байдаг. Гэтэл юун сургуулийн үйл ажиллагаа явуулах байтугай, үйл ажиллагаа явуулж болохгүй гээд шийдвэр гарчихсан байхад тэр Биеийн тамирын сургуулийг хэчнээн жил тэнд явуулж байна. Энэ сургууль чинь бол онцгой авьяастай, бусад улс орнуудад байдаг олимпын нөөц бэлтгэх ийм авьяас нь тодорсон хүүхдүүдийн сургууль биш шүү дээ. Спортын чиглэлтэй гэсэн нэртэй зүгээр Ерөнхий боловсролын сургууль. Одоо жил болгон хүүхэд нь нэмэгдсээр байгаад одоогоор мэдэхгүй 600 гаран хүүхэдтэй үйл ажиллагаа явуулдаг гэж байгаа юм. Тэгээд энэ бол ямар ч үйл ажиллагаа стандарт шаардлага хангахгүй ийм газар үйл ажиллагаа явуулаад байна. Энийг үзсэн, харсан ийм зүйл байна уу. Энийг ер нь ямар арга хэмжээ авах юм бэ. Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Ер нь энэ өвгөн Спортын ордонд үйл ажиллагаа явуулж байгаад энэ хүний амь нас, эрүүл мэнд хохирох ийм эрсдэл гарах юм бол хэн хаана хариуцлага хүлээх вэ. Үүнтэй холбоотой асуудлаа холбогдох бүх газруудад нь тавьсан, хүсэлт саналаа өгсөн. Тэгээд энэ талаар ерөөсөө шийдвэр гаргадаггүй. Энэ дээр 1 тодорхой хариулт өгөөч.

Дараагийнх нь юм бол энэ бидний хойч ирээдүй болсон хүүхэд, залуучуудын эрүүл мэндтэй холбоотой асуудал байгаа. Ерөнхий боловсролын сургуулийн спортын заалны хэмжээ стандарттай холбоотой асуудлыг 2008-2012 онд Улсын Их Хурал дээр бидний нэр бүхий гишүүд энэ асуудлыг тавьж, тодорхой стандартчилагдсан. Энэ тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Бүх ерөнхий боловсролын ялангуяа төв суурин газрын Ерөнхий боловсролын сургуулийн гадна биеийн тамирын талбай зарагдаад

дууссан. Биеийн тамирын заал танхимууд нь стандарт хангахгүй. Ялангуяа шал, агааржуулалт, гэрэлтүүлэг шал нь сүүлийн үед хөрөнгө санхүүгийн дутагдалтай холбоотойгоор цементээр цутгаад дээр нь резин будаг эсвэл энэ хулдаас дэвсдэг. Энэ бол хүүхэд, залуучуудын тэнд хичээллэгсдийн өвдөг, хөлийг бол байхгүй болгож байгаа. Яг ийм стандартын бус зааланд бэлтгэл хийж байсан энэ лигийн тамирчдаас өгсүүлээд энэ спорт, тоглоомын бусад тамирчид бол ер нь бүгд хөлгүй, үе, мөчөө солиулаад ингээд байж байна шүү дээ. Цэл залуугаараа 30 дөнгөж хүрээд л үеэ солиулж байна шүү дээ. Гэтэл энэ ерөнхий боловсролын хэчнээн мянган хүүхдүүд маань ийм стандартын шаардлага хангаагүй ийм зааланд хичээл хийснээр ямар эрүүл мэндийн эрсдэл гарах вэ. Энийг тооцож үзсэн ийм зүйл байна уу. Агааржуулалтын асуудал байгаа. Хүүхдийн тоо, норм стандартын асуудлууд байгаа. Энэ дээр анхаарахгүй бол энэ тулгамдсан асуудал болоод байгаа шүү гэдгийг хэлье. Энэ талаар тодорхой энэ 2 асуултад хариулт өгөөч.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэнгийн урилгаар Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2004 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд төрөлх нутаг, сум сургууль, ачит багш нараа эргэн дурсан гэгээн дурсамжийн эргэн дурсахуй уулзалтад чинь сайн сайхныг хүсэн ерөөе. Амжилт хүсье.

Хэн хариулах билээ. Цэрэнпилийн Даваасүрэн. Барилга, хот байгуулалтын сайд хариулна.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энэ барилгын сайдаар томилогдоод эхнээс нь хэрэгжүүлэх чиглэл өгсөн 1 арга хэмжээ бол энэ хүүхдийн аюулгүй орчинд сурах орчны асуудал юм байгаа юм. Өнөөдөр Монголчуудын хорт хавдрын өвчлөл

өндөр байгаад нөлөөлж байгаа юм бол хүнс, орчин 2 байгаа юм. Бид нар өнөөдөр хэрэглэж байгаа ундны ус маань өөрөө бараг хэрэглээний ус шахуу ус байгаад байна шүү дээ. Энэ бас нөлөөлж байгаа. Нөгөө нэг асуудал нь бол хүүхэд багачуудын маань сурч, амьдарч байгаа үзэцэрлэг, сургуулийн орчин.

Тэгэхээр энэ хүрээнд бол барилгын норм, нормативыг өөрчлөх, тэнд ашиглагдаж байгаа бараа материалуудын гарал үүслийн гэрчилгээг стандартын шаардлага хангасан, мөн хүүхдэд аюулгүй байх ийм л барилгын материалаар барьдаг тогтолцоог цаашидаа бий болгохыг бол зорино. Энэ хүрээнд бид нар барилгын стандарт, норм норматив, бараа материалуудын гарал үүслийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээг олгох энэ бүх үйл ажиллагааг цаашидаа уялдуулна. Ингэж байж хүүхдүүд маань аюулгүй орчинд сурч хүмүүжнэ. Хүүхдийн тоглоомууд байна. Бид нар өнөөдөр ерөөсөө иргэнийхээ аюулгүй орчинд амьдрах тал дээр бол үндсэндээ орхигдуулчихсан байна шүү дээ. Яг ний нуугүй хэлэхэд бол ерөөсөө л мөнгөний хэрүүлтэй зууралдсан төр л Монголд байна. Нүүрсний хулгай, банкны хулгай гээд л ингээд л ийм л юм яриад л сууж байдаг төр Монголд бий болчихсон байна шүү дээ. Харин өнөөдөр ингээд бас энэ хүүхдүүдийн аюулгүй орчинд сурах, амьдрах энэ талаар бас яриад хэлэлцүүлэг зохион байгуулаад энэ талаар Их Хурал авч хэлэлцэж байгаа нь их сайн зүйл. Тэгэхдээ энийгээ гол нь бид нар яриад орхичихдоогоо л болих хэрэгтэй. Бодит ажил хэрэг болох тал дээр нь анхаарах хэрэгтэй. Энэ хүрээнд манай яамны хувьд тэр бүх чанар стандарт, норм нормативуудын өөрчлөлтүүдийг нь бол хийнэ. Эмнэлгийн барилга, сургуулийн барилга энэ хүүхдийн орчин дээр бол энэ өөрчлөлтүүдийг хийнэ гэж ингэж зориод ажиллаж байгаа. Тийм учраас таны яриад байгаа бас энэ спортын байгууллагуудын мөн хүүхдийн спортын заал, танхим тэнд байгаа хэрэглэгдэхүүнүүд хүртэл хүүхдэд хоргүй

байх, аюулгүй байх энэ бүх стандартуудыг бас шийдэж өгнө гэж ингэж ойлгож болно. Ингээд манай ажлын хэсгийнхэн бас хариулах байх.

Г.Занданишатар: Ажлын хэсгийг нэмж хариулах уу. Ажлын хэсгийг нэмээд танилцуулчихъя. Доржпаламын Гантулга Барилга, хот байгуулалтын яамны Барилгын материал үйлдвэрлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Борисын Буяннэмэх Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга, Дангаагийн Баярболд Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Гэлэгжамцын Энхтайван гаалийн ерөнхий газрын дэд дарга, Баярсайханы Ууганбаяр Стандарт хэмжилзүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүрэнжавын Өнөрсайхан Нийтийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал, Сэржмядагийн Сүнчин Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Самбуудаваагийн Нансалмаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Гончигжавын Батмөнх Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын Хорио цээрийн хэлтсийн дарга. Ажлын хэсгээс Золбоо Барилга, хот байгуулалтын дэд сайд. 81. Нэмж хариулна.

Э.Золбоо: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэж байна. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд олон улсын байгууллагууд хамтарч байгаад энэ барилгууд дотор агаарын дотор агаарын чанарыг шинжилж үзсэн байдаг. Энэ бол сургууль, цэцэрлэг, эмнэлэг гээд ороод явна. Энэ шинжилгээний хариунаас ялангуяа сургууль, цэцэрлэг, эмнэлэг дээр химийн бодисууд болох хорттой хавдар үүсгэгч,

мэдрэлийн системд нөлөөлдөг бодисууд болох бензол, формальд гел, этил, бензол гэх мэт химийн бодисууд зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр байна гэдэг ийм урьдчилсан шинжилгээ гарсан. Тэгээд үүний дагуу Барилга, хот байгуулалтын яам бусад төрийн байгууллагуудтайгаа хамтраад ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Тэгээд энэ будгуудын үр дүнг бас яг эцсийн үр дүн гэж хэлэхэд учир дутагдалтай байгаа. Яагаад гэвэл тухайн шинжилгээг авч байхад бол барилгын улсын комисс ажиллах буюу тухайн будаг нь хатаагүй 4 хоногийн дараа авсан байдаг. Тэгээд цаашидаа бид нар яах вэ гээд бас олон улсын туршлагаудыг судлаад үзэхэд жишээлэх юм бол Европын Холбооны улсууд, Бүгд Найрамдах Хятад Ард Улс эд нар бол тухайн будгийг будаад, 20 хоногийн дараа шалгаад зөвшөөрөгдөх хэмжээнд нь байх юм бол хүлээн зөвшөөрдөг арга хэмжээ авах юм байна лээ. Тийм учраас цаашидаа бид нар энэ Монгол Улсад байгаа нийтдээ 130,000 барилгад үзэх биш ерөөсөө энэ Монгол Улсын зах зээл дээр хэрэглэгдэж байгаа түгээмэл 14 будгийг шинжилж үзэж байгаа. Сүүлийн 5 сарын хугацаанд нэлээн том хэмжээний шинжилгээ хийж үзэж байгаа. Яг энэ будгууд нь хорттой байна уу, хоргүй байна уу нэгдүгээрт.

Хоёрдугаарт хорттой байвал хэдэн хоногийн дараа хорттой нөхцөл байдал нь арилж байгаа вэ гэдгийг үзэж байгаа. Тэгээд энэ шинжилгээний хариу бол энэ 4 дүгээр сард гардуулсан. Ингэснээр чанарын шаардлага хангаж байгаа, эрүүл мэндийн шаардлага хангаж байгаа будгуудыг хүлээн зөвшөөрөе. Чанарын шаардлага хангахгүй байгаа будгуудыг бол энэ зах зээл дээр нэвтрүүлэхгүй байх, хил, гаалиар оруулахгүй байх шалгалтыг сайжруулах энэ арга хэмжээг аваад явчихна. Ингээд будагдсан байгаа будгууд дээр чанарын шаардлага хангахгүй байгаа будгуудыг тодорхойлж гаргаж ирээд хилээр өнгөрсөн хугацаанд хэдий хэмжээгээр орж ирсэн байна. Энэ нь аль сургууль, цэцэрлэг, эмнэлэг дээр

будагдсан байна гэдгийг нь гаргаж үзээд, дахиж тэр сургууль, цэцэрлэг, эмнэлэг дээрээ шинжилж үзээд хэрвээ аюултай нөхцөл байдал байх юм бол энэ аюулгүй байдалтай болох арга хэмжээг зохион байгуулна гэж ингээд зорьж ажиллаж байгаа.

Хоёрдугаарт тэр барилгын дотор агаарын чанарыг хамгийн сайжруулах нөлөөлөх зүйл бол энэ агааржуулалтын систем байгаа. Тэгээд бид бүхэн өнгөрсөн 2022 онд энэ агааржуулалтын системийг сайжруулах нь зүйтэй гээд сургууль, цэцэрлэг ялангуяа эмнэлгийн норм ба дүрмийг шинээр боловсруулаад, батлуулаад дууссан байгаа. Урьд нь бол уламжлалт аргаар, байгалийн аргаар агааржуулалт ажиллаж, дотор хортой агаарыг сорж гаргадаг байсан бол энэ удаа бол агааржуулалт нь автомат болон байгалийн аргаар хосолсон байгаа. Ингэснээр агааржуулалтын систем бол 2-3 дахин буюу 200-300 дахин хувь сайжирсан. Энэ нь бол шинэ барилгын буюу сургууль, цэцэрлэг, эмнэлэгт хэрэгжээд явж байгаа.

Г.Занданшатар: 95. Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганболдын Ганбаяр.

Г.Ганбаяр: Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмээд хариулъя. Спортын төв ордон дээр үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн асуудлыг бас нэлээн ярьж байгаа асуудал. Газрын асуудал нь шийдэгдэхгүй яваад байгаа. Бид нар бол тусдаа Спортын төв ордноос бол гаргах ёстой гэдэг байр суурьтай байгаа. Өнгөрсөн оны төсвийн төслийн саналд манай яамнаас бол энэ сургуулийг тусдаа барилгатай болгож, тусад нь барилга барья гэдэг байдлаар төсвийн хууль руу бид нар саналаа өгсөн байсан. Тэгээд 2023 онд төсөвт бол шинэ барилга, байгууламж байхгүй гээд хасагдаад ингээд явчихсан. Бид нар бол Спортын төв ордноос энэ сургуулийн үйл ажиллагааг бол гаргая гэдэг ийм байр

суурьтай сүүлийн 3 жил бид нар бол явсан. Тэгээд хоттой яриад газраа шийдээч гэдэг байдлаар бид нар нэлээн шахаад яваад байгаа юм. Газрынх нь асуудал шийдэгдэхгүй байгаа.

Таны 2 дахь асуулт бол спорт заалнуудтай холбоотой асуудал дээр яг таны хэлж байгаа бол үнэн. Тэр резин шал гэдэг зүйлийг оруулж ирээд, нэг хэсэг тийм юм явсан юм байна лээ. Одоо бол ерөөсөө тэр резин шалыг бид нар хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Бүгдийг нь солиулж байгаа. Дээрээс нь Барилга, хот байгуулалтын яам, манай яам 2 бол энэ Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны шалыг бол бид нар хуучин модон шалаар нь ингээж хүлээж авч ажиллуулж байгаа. Тийм учраас одоо бол яг таны хэлж байгаа тэр хүүхэд, багачууд тэр резин шалан дээр гэмтдэг, эгэм, шилбэ хугарах тэр эрсдэлүүдийн хувьд бид нар болохоор Ерөнхий боловсролын сургууль дээр бол бүрэн хаасан гэж ойлгож болно.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Манай Нийгмийн бодлогын байнгын хороо, манай Их Хурлын гишүүд бас нэлээн анхаарал тавиарай. Манай бодлого чинь ийм байна шүү дээ. Одоо нэг тогтчихсон тийм үзлээсээ салж өгөхгүй байна. Тухайлах юм бол төрийн эрх барих дээд байгууллага Их Хурлаас, Ерөнхийлөгчийн институтээс, Засгийн газраас ингээд ерөөсөө хүний хөгжлийн суурь нөхцөл энэ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хүрээний хандлага төлөвшлийн ийм өөрчлөлтийг хийхэд бол биеийн тамир, спорт их чухал үүрэг, ач холбогдолтой байна гэж үзээд томоохон хөтөлбөр, аян, бодлого гаргаад ингээд хэрэгжүүлэх гээд байдаг. Гэтэл одоо дунд, доод шатдаа энийг ерөөсөө хүлээн зөвшөөрдөггүй. Хуучин маягаараа биеийн тамир, спорт гэдэг бол зөвхөн олон улсад амжилт гаргадаг, цаашлах юм бол бие

бялдрын боловсрол, бие бялдрыг хөгжүүлэх л нэг нөхцөл гэж ингээж ойлгоод байдаг. Гэтэл чинь энэ цогцоороо.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэгээд энэ Бат-Эрдэнэ гишүүний яриад байгаа маш чухал асуудал байгаа. Энийг их тодорхой хариулмаар байгаа юм. Ганбаяр сайд та хэд анхаараад. Би хот, хөдөөгийн аль ч сургуульд сурч байлаа. Хөдөө ч, хотод ч маш том спортын талбайтай, хөл бөмбөг, гар бөмбөг тоглодог, уртад харайдаг, өндөрт харайдаг, ХБХ норм биелүүлдэг, турниктэй, савлууртай бүх юм байсан. Одоо энэ хотын сургуулиудын бүх биеийн тамирын талбай, хөл бөмбөгийн талбай байхгүй болсон. Газрыг нь өгөөд дуусгачихсан гэх мэтчилэн ингээд энэ сургуультай холбоотой олон асуудлууд асуугаад байна шүү дээ. Бат-Эрдэнэ гишүүн нийтийн биеийн тамиртай холбоотой. Нийгмийн эрүүл мэнд 2 чинь холбоотой. Хариулах хүн хэн байна.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 1990 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ төрөлх хот, ачит багш нараа эргэн дурссан энэ эргэн дурсахуй уулзалтад чинь өндөр амжилт хүсье.

Хариулах хүн байна уу. 92. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Үндэсний төвийн ерөнхий захирал Өнөрсайхан.

С.Өнөрсайхан: Би бол өөрөө бас ажил үүргийнхээ хувиар Биеийн тамир, спортын хорооны гишүүнээр ажилладаг. Бид ер нь энэ сургуулийн хүүхдүүдийн сургуулийн орчны асуудал, эрх хамгааллын асуудлын чиглэлээр нэлээдгүй ажлыг бол хийгээд өнөөдөр бид нар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл

мэндийн яамтай хамтраад хүүхдийн эрх, хамгааллын сургуульд суурилсан хүүхдийн судалгааг эрүүл мэндийн судалгааг бол эхлүүлээд явж байна. Энэ маань 2009 онд хийгдсэн, 2013 оноос хойш бол хийгдээгүй байгаа. Үүгээр хүүхдүүд маань өөрсдөө сургуулийн орчинд эрх нь яаж зөрчигдөж байна вэ, тэр хүүхдүүдийн сурах орчин ямар байна вэ гэдэг энэ бүх үзүүлэлтүүд 10 модулиараа бол гарч ирэх юм байгаа юм. Мөн тэд нарын асран хамгаалагч, хүмүүжүүлэгчид юу гэж үзэж байна вэ, сургуулийн багш нар, сургуулийн эрүүл мэндийн ажилтнууд юу гэж үзэж байна вэ гэсэн суурь үзүүлэлтүүд бол гарна. Энэ сургуулийн орчны асуудал дээр дотоод орчны.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. 92.

С.Өнөрсайхан: 2021 онд агаарын чанарын стандарт Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас баталж гаргасны дагуу дотоод орчны агаарын стандартыг бол батлан гаргаж байгаа. Дотоод орчны агаар дээр тавигдах шаардлагууд бол жилээс жилд маш чанга болж ирж байгаа учраас тэр бүх заалтуудыг оруулж өгсөн байгаа.

Одоогийн байдлаар ер нь сургуулийн дотоод орчин барилгын материалаас хамаарсан шинжилгээний лаборатори бүрэн бүрэлдэхүүнээрээ энэ органик бодисуудыг үздэг лаборатори бол хувийн лабораториос өөр улсын хэмжээнд бол лаборатори байхгүй ийм байж байгаа. Манай Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл зүйн лабораторийг Эрүүл мэндийн яамнаас энэ жил бүтцийг өргөтгөн өөрчилж эмнэл зүйн чиглэлээр ажиллах даалгавар өгсний дагуу бид энэ хүний эрхтэн тогтолцоо буюу биологийн дээжид хорт бодисуудыг үздэг шинжилгээнүүдийнхээ үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр явж байна. Манай дээр угаарын хийн хяналтыг бол бүрэн барьж чадаж байгаа. Органик бодисууд буюу органик бус бодисуудыг бол шинжилж чадаж байна. Органик

бодисууд дээр арайхан тоног төхөөрөмж, хүчин чадал бол хүрэлцэхгүй байгаа.

Г.Занданишатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр манай эрүүл мэндийн салбарынхан, боловсролын салбарынхан ч гэсэн ер нь нэгдсэн ойлголттой баймаар байгаа юм. Одоо жишээлэх юм бол энэ биеийн тамир, спорт гэдэг чинь хүн амын эрүүл мэндээ хамгаалах, бэхжүүлэх, эрүүлжих, чийрэгжих, цаашлах юм бол хүмүүнлэг зүрх сэтгэлийн боловсрол олгох, хандлага, төлөвшилтэй холбоотой энэ чухал үүрэг гүйцэтгэдэг ийм салбар байна шүү дээ. Танай эрүүл мэндийн салбарын чинь үндсэн чиг үүрэг, хамгийн эхний үндсэн чиг үүрэг бол нийгмийн эрүүл мэндийн асуудал шүү дээ. Гэтэл энийгээ хойно нь тавьчихаад, тэгээд л эмнэлгээ бариад байдаг. Эмнэлгээ бариад энийг хэзээ ч дуусахгүй. Эм, эмнэлэгтэйгээ хөөцөлдөөд. Манай Хууль зүй, дотоод хэргийн яам ингээд шорон байгуулаад энэ эцэс төгсгөлгүй ийм зүйл болно шүү дээ. Тийм учраас энэ мэт ийм зүйлүүд дээрээ онцгой ач холбогдол өгөөч. Энийгээ та бүхэн маань ойлгооч. Хариултаас ерөөсөө тодорхой юм.../минут дуусав/

Г.Занданишатар: Санал хэллээ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Асуулт, үг хамт явж байгаа.

Х.Булгантуяа: Энэ их чухал юм. Хүүхэд бүр эрүүл аюулгүй орчинд сурч, хүмүүжиж, амьдрах эрхтэй. Ихэнх хүүхдүүд өдрийнхөө ихэнх цагийг сургууль, цэцэрлэг дээрээ өнгөрөөж байгаа. Ер нь 90 орчим хувийг дотоод орчинд өнгөрөөдөг гэдэг ийм судалгаа байдаг юм байна лээ. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс. Гэтэл бид нар энэ дотор орчны агаарын чанарын асуудлыг ерөөсөө сайн ярьдаггүй. Тэгээд хүүхдүүдийн тоглоомын талбайн

стандарт гэхэд жил гаруйхны өмнө Нийслэл баталсан. Хүүхдийн тоглоомын талбай унаад, хүүхдээ дарсан, гэмтээсэн хүртэл асуудал гарч байсан. Тэгэхээр одоо энэ хүүхдүүдийн сурч боловсордог сургууль, цэцэрлэг, дотуур байр, хамгийн наад зах нь эмнэлэг гээд эдгээр байгууллагуудынхаа стандартыг бид нар ярих цаг нь болсон. Сүүлийн 6 жилийн дотор бид нар 175 цэцэрлэг барьсан юм байна. Одоо дахиад 112 цэцэрлэг баригдаж байгаа. 272 сургууль барьсан байна. Одоо дахиад 103 сургууль баригдаж байгаа. Ингэж олон сургууль, цэцэрлэг барьж байгаа нь сайшаалтай. Гэхдээ нөгөө талаасаа бид нар тооноос чанар ярьдаг цаг хугацаа болсон. Сүүлийн жилүүдэд хүүхдийн хорт хавдар онцгой нэмэгдэж байгаа юм байна лээ. Тэгээд үүний 1/3 нь цусны хорт хавдар, лейкеми болсон. Тэгээд үүнд бол ялангуяа энэ дотор орчны агаарын чанар, дээрээс нь нэмээд барилгын материалын асуудлууд бол маш хурцаар яригдаж байгаа. Одоо нэг ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм. Би ч гэсэндээ сургуулийн насны хүүхдүүдтэй, цэцэрлэгийн насны хүүхдүүдтэй хүн. 9 сарын 1-нд очихоор ингээд будаг нь ханхалсан сайхан сургууль гэж бид нар ярьдаг байсан. Эсрэгээрээ энэ бол будагт хүүхдүүдээ хордуулж байна гэсэн үг. Будаг ээжээ ингээд тагнайнд амтагдаад байна гэж ярьж байгаа юм. Тэр бол хүүхэд хордож байна гэсэн үг. Тэгээд дээрээс нь бөөлждөг, толгой нь өвддөг. Энэ бол хордлогод орж байна гэсэн үг. Тэгэхээр хэд хэдэн асуултууд байгаад байгаа юм. Сургууль, цэцэрлэгийнхээ стандартыг сая Барилга, хот байгуулалтын дэд сайд хэллээ. Стандартаа баталчихсан гээд. Дотор орчны агаарын чанарын стандартыг баталчихсан гээд. Барилгын материалын стандарт үүнд яаж орж байгаа юм бэ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт комисс энэ барилга хүлээж авахдаа дотоод орчны агаарын чанарыг шалгаж хүлээж авч байгаа юу. Ганцхан бид нар барилгын материалынхаа асуудал.... Пүрэвдорж

гишүүн ээ би асуулт асууж байна шүү дээ. Бие биедээ хүндэтгэлтэй хандъя л даа.... дараачийнх нь Гааль, Замын-Үүд дээр лаборатори барьж байгаа. Энэ лаборатори хэзээ ашиглалтад орох вэ. Ингээд энэ лаборатори ашиглалтад орсноор чанар муутай барилгын материал оруулахгүй байж ингэж чадах уу. Тэгж байж бид нар магадгүй чанар муутай барилгын материал орж ирэх л юм бол хаа нэгэн газар энэ бол шингээж таараа. Орон сууцад ч байдаг юм уу, оффист ч байдаг юм уу тэгэхээр ингэж чадах уу. Ингэж байж бид нар энэ эрүүл амь амьдрах орчин бас бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Тэгээд ийм 2 асуултыг эхний шатад асуучихъя.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулна. Тийм ер нь бол энэ өөрөө чухал асуудал. Тэгэхдээ бид энийг байнга л ярьсаар ирсэн байхгүй юу. Би ч гэсэн зүгээр норм стандартыг төгс болчихсон гэж хэлэхгүй шүү. Би сайжруул гэж хэлж байгаа. Яагаад гэвэл 2007 онд Боловсролын яаманд би ажиллаж байхдаа одоо яг стандартын нөгөө баригдсан Японы сургуулиуд байгаа. Яг энэ стандартыг хангасан. Тэнд будгийг нь, модон шалыг нь, ханыг нь, обойг нь, бүх юмыг нь хүүхдийн аюулгүй байх тэр бүх шаардлага стандартын дагуу барьсан сургууль бол тэр. Тэгээд үүний дагуу стандартыг өөрчилж өө гээд НҮБ-ээс төсөл хэрэгжүүлсэн. Тэгээд би ч яах вэ дараа нь тэгээд гишүүн болоод яваад өгсөн. Гэхдээ өнөөдрийг хүртэл тэр НҮБ-ээс тэр төсөл хэрэгжсэний үр дүнд энэ стандарт бий болоод явсан юм байхгүй шүү дээ. Байхгүй. Тийм учраас ингээд яриад өнгөрөөд байдгаа л бид нар болих хэрэгтэй. Нөгөө талаараа хүүхэд гэртээ ч гэсэн бас л хордоно шүү дээ. Зөвхөн сургууль, цэцэрлэг гэж бодож болохгүй. Тийм учраас энэ хилээр орж байгаа энэ хортой, хүнд буруу нөлөө үзүүлж байгаа химийн бодистой барилгын материал будаг шунх энэ бүгдийг хорих хэрэгтэй. Гэтэл өнөөдөр хувийн барьж байгаа байшин дээр ямар ч стандарт, ямар ч

хяналт байхгүй шүү дээ. Гэр хороололд барьж байгаа байшинг ямар будгаар будаж байгааг бид өнөөдөр орхигдуулчихаад байна шүү дээ. Зөвхөн сургууль, цэцэрлэг ярих гээд байна шүү дээ. Үгүй. Бүгдийг нь хамтад нь ярих ёстой байхгүй юу. Тэр хүүхэд чинь орой гэртээ харина шүү дээ, бас унтана шүү дээ. Тийм учраас л ер нь энэ бүх төрлийн барилгыг зөвхөн сургууль, цэцэрлэг гэхээр бүх төрлийн барилгад хүүхдэд, хүнд аюулгүй материалаар барьдаг. Тэрийг нь хил, гаалиар нэвтрүүлэхдээ хянадаг, тэр лабораторийг нь гааль дээр бий болгож өгөөд гаалийнхан нь үүний дагуу оруулдаг болгоод, ганзагын наймааг барилгын материал дээр нь зогсоогоод ингээд явахгүй ганзагаар орж ирж байгаа тэр барилгын материалыг чинь тэгээд л хэрэглэнэ шүү дээ. Бас л хэрэглэнэ. Бас л хэрэглэнэ. Тэгэхээр энэ дээр маш том зохион байгуулалтын арга хэмжээ авч байж, энэ байдлыг өөрчилнө үү гэхээс биш ингээд яриад өнөөдөр шиг ингээд өнгөрөх юм бол халаглаад л өнгөрнө. Тэгээд дараа нь ахиад хэдэн жилийн дараа дахиад энийгээ яриад л сууж байна. Тийм учраас хил, гааль, холбогдох бүх байгууллагууд, манай яам гээд бид нар хамтдаа энэ дээр бол эрүүл мэндийн байгууллагууд бүгд оролцоод, тэгээд зохион байгуулалтын арга хэмжээг нь аваад, төсвөөс тэр мөнгийг нь тавьж өгөөд, хил дээр тэр гаалиудыг нь энэ бүх хилийн барилгын материал нэвтрүүлж байгаа боомт бүр дээр бий болгож өгөөд, тэгээд байцаагч бүр энэ дээр хатуу хяналт тавиад явах юм бол энэ зогсоно. Тэгэхгүйгээр ингээд л ганзагаараа зөөгөөд л нөгөө хортой барилгын материалууд нь ороод л байх юм бол хүүхэд, багачууд, хүн хаана л бол хаана хордоно шүү дээ. Зөвхөн сургууль, цэцэрлэг дээр хорддог юм биш, зөвхөн эмнэлэг дээр хорддог юм биш, гэртээ ч хордоно. Тийм учраас нэн тэргүүнд шийдэх ёстой асуудал бол хүнд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа барилгын материал энэ түүхий эдүүдийг зогсоох хэрэгтэй. Тэгж л байж наадах чинь бол нэг мөр зогсоно уу гэхээс биш яг ийм

байдлаар бол яригдаад шийдэгдэхгүй асуудал шүү гэдгийг би хэлэх байна.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. “Шихихутаг” Хууль зүйн их сургуулийн Бизнесийн эрх зүйн ангийн 2в ангийн оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Энийг ер нь Засгийн газар дээрээ л ярих асуудал л даа уг нь. Давхар дээлийн 1 ийм зовлон байгаа юм. Үгүй ээ үгүй сайд нар. Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нар бие биеэсээ Их Хурал дээр асуулт асуугаад байхаар чинь. 81. Барилга, хот байгуулалтын дэд сайд Золбоо.

Э.Золбоо: Энэ барилгын материалуудыг бол ер нь хилээр оруулж ирэхгүй байх л арга хэмжээг авах ёстой юм байна лээ. Шинжилгээний дүнг нь харж байгаад. Тэгээд Замын-Үүд дээр лабораторийн барилга баригдаж байгаа. 2022 онд барилгын ажил 50%-тай явж байгаа. Энэ 2023 онд бол баригдаж дуусна. Тэгээд нийтдээ Монгол Улсын хэмжээнд 28 боомт байгаа. Бид нар ажлын хэсэг дээрээ ярьж байгаад Замын-Үүд дээрээ бол барилгын сорилт, шинжилгээний лаборатори байгуулъя гэж байгаа. Алтанбулагийн боомт дээр бас барилгын сорилт, шинжилгээний лаборатори байхгүй учраас Гаалийн ерөнхий газрын лаборатори баригдаад явж байгаа. Энэ жил дуусах юм байна лээ. Тэгээд энэ 2 боомт дээр лабораторийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулаад явах юм бол барилгын нийт материалын бараг 90 орчим хувь нь энэ 2 боомтоор орж ирж байгаа юм байна лээ. Үлдсэн 26 боомт дээрээ бид нар лабораторийн барилга эд нар барина гээд цаг хугацаа орох учраас тэр боомтоор хэрвээ хувь хүн, аж ахуйн нэгж ямар нэгэн байдлаар барилгын материал оруулж ирэх гэж байгаа бол Улаанбаатар хот дээр байгаа барилгын лаборатори дээр урьдчилж дээжээ өгч

шалгуулаад, чанарын шаардлага хангасан бол оруулж ирэх энэ нөхцөл байдлыг хангах юм бол энэ асуудал бол цэгцрэх боломжтой гэж харж байгаа. Түрүүн Булгантуяа гишүүн бас хэллээ. Яг ингээд будаг будаад будгийнхан үнэр хатаагүй байхад оруулж ирж байгаа гэдэг. Яг тийм юм байна лээ. Бүх будаг химийн орц найрлагатай учраас тэр будгийн үнэр арилж байж л ер нь аюултай нөхцөл байдал нь арилах байтал, манайх бол урьд нь бол тийм байдлаар оруулж ирсэн. Одоо бид бүхэн 1 том хэмжээний шинжилгээ хийж байгаа. Манай зах зээл дээр хэрэглэгдэж байгаа 14 нэр төрлийн будаг дээр яг хэдэн хоногийн дараа хортой байдлыг нь арилж байгаа гар гаргаж ирж байгаа. Тэгээд тодорхой 30 хоногийн дараа тэр хортой байдал нь арилахгүй байгаа будгуудыг бол хүлээн зөвшөөрөхгүй. Тэр хугацаандаа арилж байгаа будгуудыг бол хүлээн зөвшөөрөөд энэ жил Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, манай яам 3 хамтарч энэ ажлыг яаж зохион байгуулах вэ гэхээр жишээлбэл 30 хоногийн дотор арилж байгаа будгуудыг зөвшөөрөөд 8 сарын 1-ээс өмнө энэ будгийн ажлыг бүгдийг нь цогц байдлаар будаж дуусгавал 9 сарын 1-нд орж ирэх юм бол аюултай байдал нь арилах юм байна гэж үзэж байгаа. Стандартын хувьд бол Даваасүрэн сайд хэллээ. Бид нар бол стандартууд боловсруулаад явж байгаа. Бас энэ барилгын дотор агаарт дотор заслын ажлыг бол хэрхэн яаж хийх вэ, хэрхэн яаж шалгах вэ, хэрхэн яаж шалгаж хүлээж авах вэ гэдэг стандартуудыг бол боловсруулаад Стандартчилал хэмжил зүйн газар өгчихсөн. Энэ стандарт болоод гарч ирнэ. Цаашидаа ч гэсэн Даваасүрэн сайдын хэлдгээр энэ стандартуудыг сайжруулаад бүүр ингээд барилгын дотор байгаа тоног төхөөрөмж, материал бүрийг нь зааж өгвөл илүү үр дүн гарах юм байна лээ гэж бид бүхэн үзэж байгаа.

Г.Занданшатар: Ер нь энэ бол Барилга, хот байгуулалтын яамнаас илүү тэр Гаалийн ерөнхий газрын дэд дарга

Гэндэнцэвээн сонсгол дээр яриад л байсан. Баахан худлаа яриад л байсан. Эцсийн эцэст тэр хүний биед хорттой, эрүүл мэндэд хорттой юмыг гаалиар нэвтрүүлээд байгаа энэ Гаалийн ерөнхий газрын тэр Батмөнх гээд Хорио, цээрийн дарга энэ тэр гээд байсан. Тэгээд л гааль дээр байгаа авлигын л энэ эцсийн дүндээ гай зовлон шүү.

Чинбатын Ундрам гишүүн үг хэлнэ.

Ч.Ундрам: Энэ маш чухал асуудал байгаа юм. Хүн амьдралынхаа 90 хувийг дотоод орчинд өнгөрүүлдэг. Бид нар энэ гадаад орчинд байгаа агаарын бохирдол, утаа, тэгээд сайжруулсан түши гээд л зөндөө ярьсан. Маш их хэмжээний хэдэн тэрбумаар нь мөнгө, төгрөг зарцуулаад ингээд явж байдаг. Гэтэл амьдралынхаа 90 хувийг дотоод орчинд гэртээ, сургууль, эмнэлэг гээд ийм орчинд өнгөрүүлж байгаа юм. Тэгээд энэ дотоод орчин нь гадаад орчноосоо илүү хорттой тийм нөхцөл байдал үүсчхээд байна. Бид нарын энэ барилга, орон сууц, оффис, цэцэрлэг, сургуульдаа хэрэглэж байгаа будаг, эмульс энэ мебель тавилгыг нааж байгаа цавуу хүртэл дотроо формальзигид, бензол, телол гээд хорт хавдар үүсгэдэг, урагт нөлөөлдөг бүүр ийм аймшигтай бодисуудаар зарим нь хийгдчихсэн. Тэгээд энэ бол маш чимээгүйгээр бидний хойч үеийг алж байгаа. Хорт хавдрын өвчлөл маш ихээр нэмэгдэж байгаа. Улам залуужиж байгаа. Тэгэхээр энд бид нар Их Хурлын гишүүд ээ анхаарах ёстой учраас бидний гишүүд жилийн өмнө энэ сонсголыг зохион байгуулсан юм. Тэгээд өнөөдөр жилийн дараа тайлан нь орж ирж байгаа. Жилийн дараа орж ирэхэд судалгаа нь бүрэн хийгдэж дуусаагүй байна. Аль будаг, эмульс нь хорттой байгаа юм. Хэд хоногийн дараа хүн тухайн шинээр баригдсан юм уу, засвар хийгдсэн барилга байгууламжид орж болох юм. Стандарт нь бас бүрэн батлагдаагүй байна. Стандартыг нь боловсруулаад Стандарт Хэмжил Зүйн Үндэсний төвд өгчихсөн юм байна. Одоо

яаралтай тэр стандартаа батлаад хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Замын-Үүд дээр лабораторийнх нь байшинг энэ жил дөнгөж барьж дуусах гэж байгаа юм байна. Доторх тоног төхөөрөмжид нь бид нар ирэх жилийн төсвийг хэлэлцэхэд анхаарах хэрэгтэй. Тэгж байж энэ хил, гааль дээр тухайн барилгын материал нь стандарт хангаж байгаа юм уу, үгүй юу гэдгийг шинжилж нааш нь нэвтрүүлнэ гэсэн үг байх нь байна. Тэгэхээр энэ асуудлыг манай Засгийн газар нэлээн анхааралтай аваад, засаг дээрээ нухацтай ярилцаад ажлынхаа төлөвлөгөөнд оруулаад, ирэх жилийн төсвийн саналдаа ч гэсэн тэр лаборатори, тоног төхөөрөмжүүдийг нь оруулаад, ингээд анхаараад явмаар байна.

Яг ингээд ил бидний нүдэнд харагдахгүй байгаа ч гэсэн маш чимээгүйгээр бидний хойч үеийг алж байгаа ийм асуудал байна. Тэгэхээр энэ дээр анхаараасай гэж хүсэж байна. Болдог бол Их Хурлаас бид нар тогтоолын төсөл гаргаад Засгийн газарт тодорхой чиг үүрэг өгч бүр ингэж албажуулж гаргавал илүү зөв юм болов уу гэсэн ийм саналтай байна.

Г.Занданшатар: Санал тавих яах вэ, та нар жилийн өмнө Байнгын хороогоор сонсгол хэлэлцэхдээ сонсголын тайланг Нийгмийн бодлогын байнгын хороогоороо хэлэлцүүлээд Засгийн газарт чиглэл өгье гэж санал гаргаад хаасан юм байна лээ шүү дээ. Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороогоор 4 дүгээр сарын 4-нд л хэлэлцсэн. Тэгээд Байнгын хороогоор хэлэлцэсний дараа л чуулганд орж ирж байна. Тийм учраас энэ Байнгын хорооноосоо Чинбатын Ундрам гишүүн өөрөө Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж тэр үед протоколд тэмдэглэгдсэн. Тэгээд сая ч гэсэн Байнгын хороо дээрээ тэр тогтоолоо яриагүй. Тэгээд ийм салан баавгайн үлгэр шиг байж болохгүй. Ярьсан бол тэрнийгээ хэрэгжүүлж байх хэрэгтэй.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням, Болдын Жавхлан, Баагаагийн Баттөмөр нарын урилгаар Дархан-Уул аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурах эрхийг хангах хүрээнд зохион байгуулсан Хяналтын сонсголын тайланг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцлээ.

Нийгмийн бодлогын байнгын хороогоороо тэр тогтоол, чиглэлүүдээ өгч, үр дүнгээ гаргах талаар ажиллах хэрэгтэй. Одонтуяа дарга, Цэрэнпунцаг гишүүн, Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн дарга одоо Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай. Одоо Даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Гишүүдэд зарлаарай. Тогтохсүрэн даргад хэл.

Ингээд өнөөдрийн үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлууллаа.

Үдээс хойш Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонсоно.

ЗАВСАРЛАГА.

Г.Занданшатар: 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 14-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

**Улсын Их Хурлын гишүүн
Б.Баттөмөрөөс Монгол Улсын
Ерөнхий сайдад хандаж “Дарханы
төмөрлөгийн үйлдвэр” Төрийн өмчит
хувьцаат компанийн талаар тавьсан
асуулгын хариуг сонсох**

Асуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Даишэвэгийн Амарбаясгалан хариулна. Индэрт урьж байна.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-тай холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Нэг. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн өмчийн хорооны даргын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 333 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгээс “Кю Эс Си” ХХК-г үйлдвэр болон ил уурхайд зэрэг хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олируулах мөн тус үйлдвэрийн эзэмшлийн төмрийн хүдрийн ордуудаас болон “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн хувьцаанаас ямар нэг хувь эзэмшихгүй үндэсний компани юм гэсэн үндэслэлээр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг концессын гэрээгээр хувьчлах сонгон шалгаруулалтад санал болгосон байдаг юм.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийн концессын гэрээг байгуулах эрхийг Эдийн засаг, хөгжлийн сайдад олгож “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг концессын гэрээний хугацаанд “Кю Эс Си” ХХК-д шилжүүлэх ажлыг

зохион байгуулахыг Төрийн өмчийн хороонд үүрэг болгосны дагуу Төрийн өмчийн хорооны 2014 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 155 дугаар тогтоолоор “Дархан төмөрлөгийн үйлдвэр “ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кю Эс Си” ХХК-д шилжүүлсэн байна.

Хоёр.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны концессын гэрээ цуцлах тухай 148 дугаар тогтоол болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кю Эс Си” ХХК-аас буцаан шилжүүлэх, шилжүүлэн авах тухай 123 дугаар тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн концессыг хүчингүйд тооцож, төрийн өмчид буцаан авах шийдвэр гаргасан.

Мөн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн 2014-2021 оны үйл ажиллагаанд Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газраас хамтарсан хяналт, шалгалт хийсэн бөгөөд хяналт шалгалтаар “Кю Эс Си” ХХК-ийн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-д хөрөнгийн удирдлагын эрхийг хэрэгжүүлэхдээ концессын гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, олон зөрчил гаргаж, нийт 1 их наяд 233 тэрбум 781 сая 640 мянган төгрөгийн хохирол учруулсныг тогтоосон байна. Дээрх хяналт шалгалтын дүнтэй холбогдуулан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байгаа бөгөөд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-тай холбоотой нийт 8 хэрэг шүүхийн байгууллагад хянагдаж байна.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн 2014-2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон тус компанийн концессын гэрээгээр хувьчилсан сонгон шалгаруулалттай

холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд хувиалан тараасан болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, Засгийн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чулуунбаатарын Дондогмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ, “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ганпүрэвийн Дугаржав, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Өлзийбаярын Саранцэцэг.

Асуулгын хариулттай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Хассуурийн Ганхуяг гишүүнийг ирцэд орвол оруулчихъя. Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууна.

Г.Дамдинням: “Дархан төмөрлөгийн үйлдвэр”-ийг улсад авах ажлыг Улсын Их Хурал дээрээс ажлын хэсэг байгуулж миний бие ахлаад, Засгийн газар дээрээс бас ажлын хэсэг байгуулж ингэж явсаар байгаад л авсан. Тэгээд манай Баттөмөр гишүүн, Жавхлан гишүүн бид 3 бас энэ Төмөрлөгийн үйлдвэртэй холбоотой их олон санал, хүсэлтүүдийг хүлээж авч байгаа. Үүний хүрээнд манай Баттөмөр гишүүнээс бас ийм тодорхой асуулгыг тавьж энэ асуудалд нь анхаарал тавьж бид нар бас уулзалт хийгээд, ажил хэргийн уулзалт хийгээд яваад байгаа юм. Тэгэхээр би энэ нэгдүгээрт “Эрдэнэс Монгол” компанийн харьяанд оччихсон байгаа учраас “Эрдэнэс Монгол” компанийн удирдлага болон “Дархан

төмөрлөгийн үйлдвэр”-ийн 2 удирдлагаас нэг асуулт байгаа юм. Энэ компани яг одоо бизнесийн зарчмаар нь ингээд харвал цаашид явах боломжтой байна уу. Ямархуу хүндрэл бэрхшээлүүдтэй байгаад байгаа юм бэ. Саяхан ажил хэргийн шугамаар авсан мэдээллээр мөн бас ард иргэдийн зүгээс тэнд ажиллаж байгаа ажилчдын зүгээс бид нарт ирж асууж байгаа асуултууд, тавьж байгаа асуудал юу вэ гэхээр уурхайнууд маань сул зогсолттой болчихоод цалин орлогогүй болчихоод байна гэдэг ийм асуудал ярьж байгаа юм. Дарханчуудын хувьд энэ асар нөлөөтэй ийм үйлдвэр. 1800 орчим Дарханчууд ажилладаг. Монголын цор ганц хүнд үйлдвэрийн төмөрлөгийн үйлдвэр байж байгаа. Цалин нь буухад л Дарханд бол илт мэдэгддэг, эдийн засагтай нь шууд холбоотой ийм л үйлдвэр юм байгаа юм. Тэгэхээр энэ ажилчдын цалин, орлоготой холбоотой асуудал ер нь ямар болчихоод байгаа юм бэ. Яагаад энийг асууж байгаа вэ гэхээр их олон ажилчид сул зогсолттой болчихоод байна. Яах нь тодорхойгүй байна гэдэг асуудал тавьж байгаа юм.

Хоёрдугаарт энэ “Дархан төмөрлөгийн үйлдвэр” төрд ирснээс хойш энэ орон нутгийн бизнесийг дэмжих чиглэлд ер нь ямархуу ажлууд хийж байна. Орон нутгийн худалдан авалтуудыг ер нь яаж хийж байна. Дарханы жижиг, дунд бизнесүүдийг дэмжих чиглэлд худалдан авалтууд дээрээ та нар ямар бодлого хэрэгжүүлж байна. Тоо, баримттай хэлээч ээ.

Гуравдугаарт хэвлэл мэдээллийн хэрэгслээр мань мэтийнхээ нэрийг оруулаад л бас их явах юм. Томилгоо энээ тэрээ гээд. Оролцож байгаа юм бол ерөөсөө байхгүй шүү. Ер нь та нар энэ төрд ирснээсээ хойш ямархуу хэдий хэмжээний томилгоо хийгээд, ямар шалгуурууд хийгээд явж байгаа юм. Засгийн газрын энэ хэрэгжүүлж байгаа шүүр ажиллагааны хүрээнд хэд нь шаардлага хангахгүйгээр больж байгаа вэ. Энэ талаараа бас энэ олон нийтэд

дэлгэрэнгүй мэдээлэл өгчих хэрэгтэй байна. Тэгээд тодруулна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. 84. Ганпүрэвийн Дугаржав.

Г.Дугаржав: Эрхэм гишүүд, Их Хурлын даргад энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Дархан төмөрлөгийн үйлдвэр 2022 оны 4 дүгээр сард өмнөх концесс хэрэгжүүлж байсан байгууллагаас төрд шилжсэн. Засгийн газар шийдвэрээ гаргасан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтоолоо гаргаад ингээд төрж шилжсэн. Үүнээс хойш бол “Кю Эс Си” компанийн ажиллаж байсантай харьцуулах юм бол яг одоогийн байдлаар төмөрлөгийн үйлдвэрт 1524 ажилтан ажиллаж байна. Цалингийн ерөөсөө хийдэгдэл гараагүй. Одоогийн байдлаар цалин 38 хувиар нэмсэн. Манай дундаж цалин ойролцоогоор 2 сая гаран төгрөгтэй байгаа. Сул зогсолтод 280 хүн байгаа. Сая Дамдинням гишүүний асуусны дагуу хэлэхэд. Өмнө нь бол яах вэ бас оргил үе дээрээ 564 хүний сул зогсолт бол гарч байсан юм байна лээ. Цалин 1 ч удаа тасраагүй. Харин бид нар сая 2 дугаар сарын 1-нд 13 дахь сарын цалин өгсөн. Одоо бас дансанд хангалттай харилцах мөнгө байна. Өнгөрсөн жилийн байдлаар сард бол 3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан. 9 сар хүртэл. 10 сард би ажил авсан. Оны эцсээр манайх 1.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан. Эхний улирал дээр одоо бид нар хамгийн багадаа 7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байгаа. Тийм учраас бол цалин дээр бол хүндрэл гарахгүй гэж бодож байна. Манайх бизнесийн зарчмаар явна. Ерөнхийдөө яваад байхад бол боломжтой байгаа.

Сул зогсолтын нөхөн олговор дээр бид нар 60 хувь байсныг 80 хувь болгож өгч байгаа. Энэ сул зогсолт дээр байгаа 280 гаруй хүн өмнө нь нөгөө “Кю Эс Си” компанийн ажиллаж байх үед ихээхэн

хэмжээний нөгөө ажиллах хүч тийм хүчин чадлыг бэх зохиомлоор бий болгосонтой бас холбоотой байгаа юм. 2 уурхай дээр 2, 2 сая тонны хүчин чадал үүсгэгчхсэн. Тэрийгээ дагаад хүний нөөц үүсгэгчхсэн ийм байсан. Тийм учраас бол бид нар яалт ч үгүй 280 орчим хүний сул зогсолт бол байж байгаа. Энийг бол бид нар үе шаттай багасгаад явна гэж ингэж ажиллаж байгаа. Мөн ажилласан жилийн нэмэгдлийг бол бид нар 2022 онд 40,000 байсан бол одоо 200,000 хүртэл нэмэгдүүлсэн. Ер нь 3-20 хувь нэмэгдүүлж байгаа. Дээд хязгаар дээрээ 20-оос дээш жил дээр 58,000 байсныг бид нар 390,000 болгож нэмэгдүүлсэн ийм цалин хөлстэй холбоотой зүйлүүд явагдаж байна. Орон нутгийн худалдан авалт гэхээр бид нарыг тойрсон нэг ийм асуудал байдаг. Манайд экспортын баяжмалаас гадна 58, 52 хувийн агуулгатай экспортын баяжмалаас гадна 50-аас доош хувь хувийн агуулгатай 20-50 хувийн агуулга дээр бол завсрын баяжмал гэж баяжмал байгаа. Энийгээ бол манайхыг тойрсон 10 гаруй үйлдвэр бол энэ манай завсрын баяжмалыг аваад дахин баяжуулалт хийгээд, завсрын хүдрийг авч баяжуулалт хийгээд ингээд бол нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн хийж экспортод гаргаж, ашиг, орлого олж байгаа. Энэ 10 гаруй үйлдвэр байдаг. Ковидын үед бол нэлээд зогссон. Та бүхэн мэднэ АМНАТ-ын асуудлаар энэ бол нэлээд тэд нарын хувьд бол хүндэрч байсан. Тэдний хувьд бол. Бусдаар бол бид орон нутгийнхаа аж ахуйн нэгж, бизнест бол энэ хүрээнд л хамтарч ажиллаж байна.

Томилгооны хувьд бол намайг ирэхэд байсан баг бол бараг бүтнээрээ ажиллаж байгаа. 10 дугаар сард авсан. Ажил авахад ажиллаж байсан 3 газрын дарга, нэгжгээд хэлтсийн дарга нар бол ажиллаж байгаа. Бусдаар бол миний хариулт ийм байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Наранцогт дарга.
83.

С.Наранцогт: Дамдинням гишүүний асуултад хариулъя. “Дархан төмөрлөгийн үйлдвэр” 2022 оны 11 сарын 30-ны шийдвэрээр “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд ирж ажиллаж байгаа. Ингээд бид нар таны асуусантай холбоотойгоор нэгдүгээрт урт, дунд хугацааны стратеги төлөвлөлтийн асуудал, богино хугацаанд хэрэгжүүлэх асуудал дээр бид нар ажиллаж байна. 2 сард би Дархан төмөрлөгт хугацаатай 11 заалт бүхий ийм албан даалгавар хүргүүлсэн. Энэ албан даалгавраар яг энэ тулгамдаж байгаа асуудлуудтай бүгдийг нь холбож авч үзэж байгаа. Ер нь нэгдлийн хувьд хөгжлийн үндсэн чиглэлийг бид нар 15 жилээр, стратеги төлөвлөлтийг бол 5 жилээр боловсруулах энэ ажлаа хийгээд явж байгаа. Энэ ажил бол нэлээн хийгдээд явж байна. Энэ дээрээ бол энэ компани 15 жилд ямархуу түвшинд очих вэ, 5 жилийн хугацаанд ямар түвшинд очих вэ гэсэн энэ стратеги төлөвлөлт, үндсэн чиглэл гараад ажиллаж байгаа юм. Тэгээд тулгамдсан асуудлууд бол юу байна вэ гэхээр энэ стратеги төлөвлөлттэй холбоотой асуудлыг бол энэ 4 сардаа компанийн санал боловсруулагдаж ирнэ. Ажлын хэсэг гараад ингээд ажиллаж байгаа. Энэ дээр бас ойрын хугацаанд шийдэгдэх шаардлагатай хэд хэдэн үүрэг даалгаврууд өгөгдсөн. Энэ дотор бол таны ярьж байгаа энэ компанийн зохион байгуулалт, бүтцийн хамгийн оновчтой үр дүнтэй байх саналыг боловсруулах үүрэг даалгавар өгөгдсөн. Одоогийн байдлаар сая Дугаржав захирлын хэлдгээр үйл ажиллагааны хувьд нэлээдгүй илүү орон тоотой, цаашидаа яг энэ чигээрээ явахад бол нэлээн хүндрэл учрах ийм төлөвлөгөөтэй байгаа. Компани бол жилдээ сая тонн хүдрийг борлуулах ийм экспортлох боломжтой. Одоогоор 2 сая тонн хүдрийн овоолго байгаа. Тэгэхээр нэмээд нэлээн хэмжээгээр хүдрийн олборлолт явуулна гэхээр нэгдүгээрт техник, тоног төхөөрөмжийн бололцоо нь өөрөө нэгдүгээрт бага. Тэгээд маш их

хэмжээний зардал гарна. Тэр зардлаа борлуулалтаараа нөхөх бололцоо байхгүй ийм хүндрэл үүсээд байгаа юм. Тийм учраас тэр сул зогсолт гэдэг асуудал үүсэж байгаа. Монгол ган цогцолбортой холбоотой эхний ээлжийн нэн түрүүн хэрэгжих ёстой 2, 3 төсөл бид нар зарласан байгаа. Тэгээд тэр төслийн ажил эхлэхээр энэ сул зогсолттой хүмүүсээ тийшээ шилжүүлж ажиллуулах, цаашидаа бол ер нь энэ бүтэц, зохион байгуулалтын хувьд бол энэ дээр нэлээн өөрчлөлт хийж явахаас өөр аргагүй. Ингэхгүй л бол энэ компани яг бизнесийн зарчмаар, өөрийнхөө орлого, борлуулалтаар үйл ажиллагааныхаа зардлыг нөхөөд явах ийм боломжгүй байж байгаа.

Дээр нь нэмээд бол энэ уурхай дээр явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой нэлээд сорчилж олборлосон ийм нөхцөл байдал үүсчихсэн байгаа. Энэ асуудлыг цэгцлээд 2 уурхайнхаа бүрэн баялгийг бүрэн ашиглах, технологийн дагуу олборлолтоо явуулах, үүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулах, боловсруулах үйлдвэрийнхээ хүчин чадлыг өргөтгөх, ингээд нойтон баяжмалын үйлдвэрийг уурхай дээрээ бас барих, төслийг эхлүүлэх ийм ажлууд бол тулгамдсан. Энэ дээр анхаарал тавьж ажиллаж байгаа юм.

Г.Занданшатар: Дамдинням гишүүн тодруулъя. 1 минут.

Г.Дамдинням: Тэр орон нутгийг дэмжих чиглэлд Өмнөговь аймгаас бас туршилага авч ажиллах хэрэгтэй байгаа юм Дугаржав захирал аа. Ажилчдынхаа хувцсыг, ажилчдынхаа хоолыг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийг гээд энэ уурхай чинь өөрөө хажуудаа, дэргэдээ уурхай болон энэ үйлдвэр чинь хажуудаа, дэргэдээ бас энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих ийм зайлиггүй шаардлагатай болдог, хэрэгцээ байдаг тэд нараас юм авах. Энд нь Дарханчуудаа дэмжих, Дарханыхаа

бизнесийг дэмжих чиглэлд анхаарах ёстой шүү.

Хоёрдугаарт энэ Дархан-Уул аймгаас авсан мэдээллээр энэ төсвийн орлого бас тасалдуулаад байна гэсэн ийм асуудал яриад байгаа юм. Та болохоор энд мөнгө байгаа гээд байдаг. Энэ ер нь ямар учиртай юм. Та нар ер нь Дарханд төлөх ёстой юмаа төлж байгаа юм уу. Орж ирэхгүй байгаа л юм яриад байх юм.

Гуравдугаарт энэ ажилчдыг сэлгэн ажиллуулах, тэр ажлын байраас нь байхгүй болгохгүй байх тал дээр нь та нар бас анхаарч бодлого хийх ёстой шүү гэдгийг захъя. Саяын асуултад хариулаарай.

Г.Занданшатар: Асуултад хариулъя. 84. Дугаржав.

Г.Дугаржав: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Хэлсэн зөвлөмж юмыг бол ойлголоо гишүүн ээ. Тэр нөгөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр тэр хувцас, хоол хүнс байдаг уу тэр чиглэлээр бол анхаарч ажиллая. Тэр орон нутгийн төсөв бүрдүүлэх асуудал дээр болохоор манайх өмнө нь цөмөрсөн их өр байгаа юм. “Кю Эс Си”-ийн үед тавьчихсан 123 тэрбум төгрөгийн татварын өр байгаа. Тэгэхээр тэр маань ингээд бас суугдаад явчихдаг юм байна лээ. Бид нар бол орон нутгийн санхүүдээ татвар юмаа төлөхөөр тэр маань нөгөө өмнөх рүүгээ шууд өмнөх жил рүүгээ суутгагдаад аваад явчихдаг ийм юм байна лээ. Тэгээд Сангийн сайдтайгаа бас бид нар яриад, үүний учир зүйг нь гаргаад, цаашаа нэмж төсөв бүрдүүлэх дээр нь анхаарахгүй бол бас их улаан гэрэл ассан ийм хүнд нөхцөл байдал үүссэн гэдгийг бол ойлгосон байгаа. Тэгээд анхаарч ажиллая гишүүн ээ.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит аж ахуйн нэгжийн тухай тайлан, мэдээлэл яригдаж байна л даа. Яг л дахиад л бид нарын ярьдаг үндсэн сэдэв аж ахуйн үйл ажиллагааг төр явуулах уу, явуулахаар бас яг юу болдог вэ гэдгийн жишээг л бид нар энд, дунд нь бас концесс нэрээр хувьчилж үзсэн. Бас ингээд будилаан хуулийн байгууллага гээд баахан юм яригддаг. Сая ярьж байгаа ярианаас үзэхэд өнгөрсөн 4 дүгээр сард гэхээр яг 1 жил болж байгаа юм байна. Энэ компани төрд буцаж ирээд. Дахиад тэр захирлын ярианаас 10 дугаар сард томилогдож очсон гэж байна. Тэгэхээр 1 жилийн дотор хэд дэх захирал нь юм, томилогдсон юм байна. Дахиад нөгөө засаглал энэ тэр. Дахиад тэр ярианд гарч байгаагаар 1-2 сая тонны хүдэр экспортолдог, боловсруулдаг гэж байна. Нөгөө арматур маань хаачсан юм бэ гэх мэтээр ингээд тойроод яривал энэ дээр засаглалын болоод олон зүйлүүдийг ярьж болох нь л дээ. Тэгэхээр би 1 тодорхой асуулт асуух гээд байгаа нь энэ чинь хэдхэн жилийн хооронд 3 өөр өмчлөл болоод явчхаж. Энэ 3 дээр 1 харьцуулсан тоог хэлж өгөөч. Ер нь концессоор шилжихээсээ өмнө ямар үр ашигтай, ямар борлуулалт хийдэг, ямар бүтээгдэхүүн гаргадаг компани байсан юм. Концессын жилүүдэд ямар борлуулалтын орлоготой, ямар үр ашигтай, ямар компани байсан юм. Одоо төрд буцаж ирээд ямар ямар үр дүнтэй, ямар үйл ажиллагаатай яг яаж байна. Болж өгвөл товчхон, тодорхой тоонуудаар энэ 3 дээр харьцуулалт хийж өгөөч.

Тэгээд төгсгөлд нь тэгээд цаашид энэ компани яах юм. Ингээд яг л одоо өнөөдөр сүүлийн үед хэвлэлээр харагдаад байсан тэр “Хөтөл” гээд компани байгаа. Төр даваад сайхан болж байна л гэж байсан. Нийлүүлэлтийн хомсдол зах зээл дээр үүсгээд, өнгөрсөн жил цементийн үнэ хэд болчхов. Дахиад л нэг сайхан, сайхан л юм яриад байдаг. Өнөөдөр дахиад л жилийн дараа харахад

нөгөө сайхан болсон төрийн менежмент гэдэг чинь угаасаа л ийм л юм. Далд, нууц явдаг нэг өдөр тэсэрдэг. Яг л Дарханыг задлаад үзвэл авах юмгүй л юм байгаа шүү дээ. Энэ “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” бол. Тэгэхээр цаашидаа энэ компани яах юм. Бас л ингээд л баахан хулгай, зэлгий хуулийн байгууллага нэг ийм шоронгийн дамжаа шиг юм ажиллуулаад л, ингээд төрийн өмчит компаниуд ингээд ийм байдалтай л яваад байх юм уу. Ер нь цаашидаа энэ дээр ямар бодлого, чиглэл барьж ойрын бодлого чиглэл, төлөвлөгөөнд ер нь яана гэж туссан байгаа юм. Энэ тухайгаа мэдээлэл өгөөч.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. 83. Өглөг, авлага бүх тооцоогоо танилцуул гэсэн.

С.Наранцогт: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ компани бол анх Японы тусламжтай таны хэлж байгаа арматур үйлдвэрлэх, хаягдал төмөр боловсруулах ийм чиглэлээр байгуулагдаад ингээд энэ концессын гэрээгээр хувийн хэвшил үйлдвэрлэх хувийн хэвшилд концессын гэрээгээр шилжүүлээд энэний зорилго нь бол энэ үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх, цэвэр төмөр ангижруулж боловсруулах үйлдвэр барих, тэрэнтэй холбоотой дэд бүтэц барих, нойтон баяжмалын үйлдвэр барих ингээд энэ энэ 5 зүйлийн том хөрөнгө оруулалт хийх ийм үүрэг хүлээж байгуулагдсан. Тэгээд тэрэнтэй холбоотой ажлууд хийгдээгүй учраас ингээд концессын гэрээ цуцлагдсан байгаа юм аа. Тэрийг яаж тоон үзүүлэлтээр таны хэлдгээр харах вэ гэхээр 2014 оноос эхлээд тоон үзүүлэлтийг хэлье. 2014 онд энэ компани 51.9 мянган тонн ган бүтээгдэхүүн, өөрөөр хэлбэл эцсийн бүтээгдэхүүн боловсруулаад 532.8 мянган хүдрийн баяжмал гаргадаг байсан байна. Тэгээд ингээд Концессын гэрээ шилжсэнээс хойш бол энэ ган үйлдвэрлэл нь өөрөө эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл бууж явсан. 2015 онд 29.4, 2016 онд 15.5. яах вэ

2017 онд жоохон нэмэгдээд 31.6, 2018 онд 26.1, 2019 онд бүр буураад 13.3, 2020 онд 9.4 гээд энэ бэлэн бүтээгдэхүүн, ган бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл ингээд буураад байгаа юм. Нөгөө талдаа энэ баяжмал шууд олборлоод экспортлох нь шууд эрс нэмэгдээд явчихсан. 2014 онд 532,000 тонн байсан бол, 2015 онд 543, 2016 онд ингээд 1 сая ингэж өссөөр явж байгаад хамгийн оргил үе нь бол 2020 онд 2 сая 800 мянган тонн хүдрийг боловсруулж, экспортолж байгаа. Яг 2020 онд ган эцсийн бүтээгдэхүүн бол хамгийн бага 9.4 мянган тонн. Ийм байдлаар үйл ажиллагаа нөгөө тавьсан зорилгоосоо эрс өөр тийшээ явсан гэдэг тоон үзүүлэлт эндээс ингээд харагдаж байна.

Төрд ирснээсээ хойш энэ 2023 оны төлөвлөгөөгөөр бол аль аль мэдээж ган бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ бол нэмэгдүүлнэ. 33 мянган тоннд хүргэнэ. Энэ төмрийн баяжмал олборлолтоо бол энэ 1 сая 700 мянгад хүргэх ийм зорилт төсөв төлөвлөгөө нь бол батлагдаад явж байгаа. Засаглалын хувьд бол мэдээж ярьж байгаа төрийн өмчийн компаниуд дээр нэлээдгүй асуудлууд байгаа учраас ямар ч байсан “Эрдэнэс Монгол”-ын хувьд энэ уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компаниудыг нийлүүлээд засаглалыг олон улсын сайн туршилага, олон улсын уул уурхайн компаниудын сайн засаглалын туршилагыг нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газар дээр нэлээдгүй шийдвэрүүд гараад, ажлаа зохион байгуулаад “Эрдэнэс Монгол” компанийн харьяанд энэ чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшдэг бүх төрийн өмчит компаниудыг нийлүүлээд нэгдсэн стратеги төлөвлөгөө боловсруулагдаад, нэгдсэн дүрэмтэй болоод ийм ажлууд хийгдэж байна.

2022 оны сүүлээс эхлээд энэ ажил эхэлсэн. Өнгөрсөн 4 сарын хугацаанд бол 2 удаа нэгдлийн дүрэм өөрчлөгдсөн. Одоо бүх компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болох гэж байна. Энэ хурлаар ТУЗ-ийн гишүүд болоод энэ дүрмийн өөрчлөлтүүд орно. ТУЗ-ийн гишүүн дээр

бол хараат бус гишүүний тоог бол нэлээд нэмэгдүүлж байгаа. Өөрөөр хэлбэл төрийн төлөөлөл хуучин нэлээн давамгай байдаг байсан бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Хамгийн гол нь саяын тайлангуудыг харахад угаасаа л энд болж байгаа юм байхгүй л дээ. Эцсийн бүтээгдэхүүн гаргадаг байсан бол бараг хийхгүй болж байгаа юм байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” гээд том нэртэй. Тэгсэн мөртөө хүдэр ухаад шороотой нь ухаад урагшаа гаргадаг ийм ажилтай. Тэрийг яг үнэндээ бараг л хэтрүүлээд хэлбэл хэн ч хийчихдэг ийм л ажил. Нэг их том том нэртэй. Тэгэхээр ер нь цаашидаа тэгээд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ч байна уу, энэ “Хөтөл” ч байна уу энэ төрийн өмчит ийм аж ахуйн нэгжүүд, тэр тусмаа цементийн үйлдвэр чинь угаасаа хувийн салбар маш ихээр хийдэг болчихлоо. Энэ зүгээр ердийн бизнес л болчихож байна шүү дээ. Энэ төмөрлөгийн газар ухаад хүдэр гаргах ажлыг чинь хэн ч л хийнэ шүү дээ. Тэгэхээр энэ бүх ажлуудыг цаашидаа ингээд төрд байгаад тийм ТУЗ-ийн гишүүдийг солино, өөрчилнө гэх замаар ингээд л байгаад байх юм уу. Энэ олон улсын нээлттэй тендер зарлаад.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Наранцогт дарга хариулъя. 83.

С.Наранцогт: Би түрүүн Дамдинням гишүүний асуултад бас хариулахдаа дурдсан. Энэ 5 жилийн стратеги төлөвлөгөө, 15 жилийн үндсэн чиглэл дээр таны ярьж байгаа зүйлүүд бүгдээрээ орж байгаа. Мэдээж хэрэг бид нар эцсийн бүтээгдэхүүн боловсруулах ёстой. Тэгэхээр эхний ээлжид энэ уурхай дээрээ бид нар, нойтон баяжуулах үйлдвэр, тэгээд металл боловсруулах үйлдвэр, одоо байгаа үйлдвэрийн өргөтгөл гэсэн төслүүд эхний шатад хэрэгжинэ. Энэ төслүүд мэдээж хэрэг

таны хэлж байгаачлан төр-хувийн хэвшлийн түнш, олон улсын нээлттэй тендер, гадаадын хөрөнгө оруулалтуудыг татах маягаар хамгийн одоо зөв хэлбэрээр хэрэгжүүлнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Төслүүдийн нэгдлийн хэмжээний төслүүдийг эрэмбэлэх ажил хийгдэж байна. Энэ дээр Дарханы төмөрлөг дээр эхний ээлжид энэ эцсийн бүтээгдэхүүн гаргах төслүүд бол ингээд ороод явж байгаа. Ер нь 2050 дээр, Шинэ сэргэлтийн бодлого дээр бид нар бол Монгол ган цогцолбор гэсэн том .../минут дуусав/

Г.Занданишатар: Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Дарханы төмөрлөгийн үйлдвэр 1994 онд ашиглалтад орсон. Энэ 30 жилийн хугацаанд тэр төмрийн хүдрийг л авах чиглэлд л гол анхаарлаа хандуулсан бол боловсруулах үйлдвэр дээрээ 1 шон ч босгоогүй. Энэ нь тэр монгол ган 1, 2 гээд л ингээд ярьдаг. Өнөөдөр Монгол Улсын цувимал төмрийн хэрэгцээ 700, 000 тонн байдаг. Тэгээд монгол ган 1, 2-ыг хийснээрээ 305-ийг хангана гээд байдаг. Тэгээд одоо хүртэл энэ 30 жилийн хугацаанд энэ засваруудаа ашиглалтад ороод Монголын хэрэгцээг хангачих боломж байсан уу гэвэл байсан. Өнгөрсөн хугацаанд чадсангүй. 1 тонн төмрийн хүдрээ 50-70 доллароор гаргаад, буцаад 700-1000 доллароор арматур худалдаж авч байна шүү дээ. Тэгээд энэнээс болоод энэ орон сууцын үнэ буурахгүй байгаа гэх мэтийн маш их олон асуудлууд байна л даа. Өнөөдөр төлөөгүй татвар 123 тэрбум төгрөг байна. Орон нутагт 1.4-ийг төлж чадахгүй байна. Орон нутаг нь байнга зарга хийж байгаа. Хэд хэдэн асуултууд байна. Нийт энэ “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийн өр бол 805 тэрбум төгрөг байгаагаас “Кю Эс Си”-тэй холбоотой 508 тэрбум төгрөг байна. Энэ үл маргах журмаар төлөх тийм бас өр ч бас байна.

Энэ дээр ямар юмнууд хийгдэж байна. 1 дэх асуулт.

2 дахь асуулт бол юу гэхээр нийт “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-т 303 техник байдаг. Өнөөдрийн байдлаар 77 ширхэг нь ажилтай, парк ашиглалт 22.6 хувь, үлдэж байгаа 77.4 хувь нь ашигладаггүй. Энийг ашиглалттай болгох чиглэлээр юу хийгдэх гэж байна гэж.

3 дахь асуулт бол юу гэхээр концессын гэрээнээс үүдэж улсад хохирсон хохирол нь бол 1 их наяд 373 тэрбум төгрөг гэж байгаа. Энэ дээр сүүлийн үед энэ эрүүгийн хэргийн хохирлууд нэмэгдэж байгаа. Энэ хохирлуудаас шүүхийг хүлээхгүйгээр төлөх боломжтойгоор гэрээ хэлцэл хийгдэж байгаа юм байна уу, үгүй юу гэж.

Дараагийн “Кю Эс Си” үндэслэлгүй концесс болсон гээд шүүхдэж байгаа гэсэн. Энэ хэвээрээ шүүхдээд явж байгаа юу, байж байгаа юу гэж.

Дараагийн асуулт бол юу гэхээр энэ 3 сая тонн төмрийн баяжмал байгаа. 70 доллароор бодох юм 210 сая доллар. Энэ жил 1.5 саяыг нь экспортод гаргана гэвэл сард 30 цуваа хэрэгтэй байгаа. Ачааны 1 мянган вагон хэрэгтэй. Зүтгүүр 2 мянган ширхэг хэрэгтэй. Энийг авах чиглэлээр энэ “Эрдэнэс Монгол” ямар бодлого барьж байна. Тэгээд энэ “Монгол ган” цогцолборыг хэрэгжүүлэхэд тэр эрчим хүчний асуудлаа яаж шийдэх гэж байна. Хаягдал төмрийг авах чиглэлээр ямар ажлууд хийх гэж байна. Дэлхийн зах зээлийн үнэ өнөөдөр далианы үнэ 1 тонн төмөр 125 доллар байгаа. 2022 оны гаалийн статистикаар 74 доллар худалдаж байгаа. Тэгээд энэ дэлхийн зах зээлийн үнэд хүргэх чиглэлээр юу хийх гэж байна. Биржээр худалдах боломжуудыг та нар судалж байна уу. Уул уурхайн бирж нээгдээд.../минут дуусав/

Г.Занданишатар: Хэн хариулах уу.
84.

Г.Дугаржав: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Өр төлбөр шүүх дээр явж байгаа асуудлууд байгаа. Ерөнхийдөө яг өнөөдрийн байдлаар 805.8 тэрбум төгрөгийн өр төлбөр үүссэн байгаа. Энэ бол 94 хувь нь “Кю Эс Си” компанид хамаарах ийм өр төлбөр байгаа. Зээл 26 хувь нь энэ юуны. Бид нар нөгөө “Дархан төмөрлөгийн үйлдвэр”-т нэн шаардлагатай биш ийм зээлийг 2 банкнаас Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар банкнаас авсан зээл 26 хувийг нь дарж байгаа. Урьдчилж олсон орлого 16 хувь байгаа. Энэ 40 гаран компани байдаг үүнээс 18 нь гадаадын компани байгаа. Татварын өр 44 хувийг нь эзэлж байгаа. “Кю Эс Си” компани өөрөө авсан 8 хувь нь. Ингээд 94 хувь нь манай өр төлбөрийн холбогдох хэсэг нь бол “Кю Эс Си” компанид хамаарч шүүх рүү хууль хяналтын байгууллага руу явж байгаа. Үүнээс бол 1 эрүүгийн хэрэг маань 700 орчим тэрбум төгрөгийн хохирол бол АТГ-ын шинжээч дээр батлагдаад, прокурорын хяналтад шилжсэн байгаа. Яг одоогийн байдлаар. 700 тэрбум нь тогтоогдоод, тэгээд тэр нь прокурорын хяналтад 12 сарын сүүлээр шилжсэн. Хохирол бол ерөнхийдөө 1.3 их наяд байж байгаа. Техникийн хувьд сая Баттөмөр гишүүн асууж байна. Манай дээр 304 техник бүртгэлтэй байгаагаас 51 нь “Кю Эс Си”-ийн паспорттой гэсэн үг. Тэгэхээр бидэнд 253 техник үлдэж байгаа юм. Үүнээс ажиллаж байгаа нь 77 техник байгаа. Энэ техникийг бид ашиглалтыг нэмэгдүүлэх талаар шат дараатай арга хэмжээ авах ёстой. Яг өнөөдрийн байдлаар бид бол ийм бүрэлдэхүүнээр ажиллаж байгаа. Түрээсээр нэмж 18 техникийг авч ажиллуулснаар бид нар бол уулын ажлаа хэвийн явуулж байна гэж байгаа юм.

Захиргааны хэдэн хэрэг байгаа. 3 хэрэг бидэнд хамаарч байгаа ийм 3 хэрэг байгаа. Үүний 1 нь бол сая Баттөмөр

гишүүний асуудаг концессыг үндэслэлгүй цуцалсан гэсэн ийм хэрэг байгаа. Энэ асуудлаар бол гомдол гаргасан. Энийг бид бас шатнууд руу нь явж байгаа. Дараагийн Захиргааны хэрэг бол Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас нөхөн төлбөр шаардсан 1 ийм хэрэг захиргааны хэрэг дээр явж байгаа. Сүүлд нь сая гарсан 1.2 их наядын хохирлын асуудлаар хяналт шалгалтын дүн дээр гомдол гаргасан. Ийм 3 захиргааны хэрэг. Ер нь бол 5 захиргааны хэрэг явж байгаагаас энэ 3-ыг нь хүчингүй болгох талаар бас манай өмгөөлөгчдийн баг ингээд ажиллаж байгаа. Шат шатын шүүхүүд рүү явж байгаа. Ийм байж байгаа.

Тэгээд 3 сая тонн баяжмал бол гаргаад тавьчихсан байгаа. Үйлдвэрлэлээ гаргаад тавьчихсан байгаа. Үүнийгээ экспортлоод сая Баттөмөр гишүүн яг хэллээ. Тэр вагоны хэрэгцээг бол манайд хэллээ. Цувааны тоог бол яг таг тооцоолж хэлж байна. Тэгээд энэ чиглэлээр вагоны хүчин чадлыг яаж нэмэгдүүлэх талаар юу хийх вэ гэдгийг Наранцогт даргаас сая бүр нэр заагаад асуучих шиг боллоо. Тэгээд Наранцогт дарга маань толгой компанийн хувиар энэ талаар бол хариулт өгөх байх.

Биржээр арилжаалах тухай бол бид Хөрөнгийн биржийн удирдлагатай ярьж байгаа.../минут дуусав/

Г.Занданишатар: Наранцогт дарга хариулъя. 83. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирал.

С.Наранцогт: Баттөмөр гишүүний тэр вагоны талаар хариулахад вагон дээр 1 үндсэндээ хэд хэдэн асуудал байна. Нэгдүгээрт энэ Дархан төмөрлөгөөс 15 сая доллар аваад вагон авна. 700 вагон авна гэдэг зүйл явагдсан. Тэгээд энэ нь мөнгийг нь авангуутаа энэ зураг төслийн институт гээд өөр компани дээр энэ вагонуудынх нь гэрчилгээг гаргаад, тэгээд тэр авсан мөнгөө бол энэ Дарханд

бол удаан хугацаагаар түрээслэх түрээсийн гэрээ байсан юм гэдэг ийм тайлбар хэлээд, ингээд маргаан үүсчихсэн. Тэгээд энэ маргааны асуудал яаж байна вэ гэхээр хууль хяналтын байгууллага дээр шалгагдаад энэ багц хэргийн нэг бүрэлдэхүүн болоод ингээд явж байгаа юм. Тэгэхдээ бид энэ дээр Улаанбаатар Төмөр зам, Монросцветмет мөн манай нэгдлийн харьяа компани байгаа. Тэгээд энэ дээр бол үлдсэн вагонуудаа боломжийн хэмжээгээр хуваарилаад, Дархан төмөрлөгөөр 400 вагон хуваарилагдаад энэ экспортод явж байгаа. Энэ дээр бас дахиад маргаан гарч байгаа учраас бид нар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бас манай хувьцаа эзэмшигчдээс үүрэг өгөөд өнөөдрөөс бид нар бас шалгалтаар очиж ажиллана. Энэ дээр яг бодит байдлын энэ маргаануудыг бас нэг талд нь цэгцлэх ийм ажил хийж байгаа. Энэ 700 вагоны бол 100 нөгөө эвдрэлтэй, 150 нь тэр зураг төслийн институт гэж компани дээр, үлдсэн вагоныг нь бол энэ Монросцветмет, Дархан төмөрлөгийн үйлдвэр дээр явж байгаа. Мэдээж нөгөө манай хоногт гардаг цувааны квот, лимит мэдээж энд хамаарна. Үүнээс хамаараад экспортын хэмжээнд хязгаарлагдах хүчин зүйл нь яалт ч үгүй вагон болчхоод байгаа. Тэгээд энэ вагоныг нэмэгдүүлэх талаар бас компани, Дархан төмөрлөгийн үйлдвэр өөрсдөө бас тодорхой хувилбарууд гаргаж танилцуулах чиглэл, үүрэг өгөгдөөд ажиллаж байна. Бид энэ Улаанбаатар Төмөр зам холбогдох газруудтай хуваарилаад хамгийн боломжит хэлбэрээр л энэ вагоныг Дархан төмөрлөгийн үйлдвэр дээр хуваарилуулаад бидний зорилго бол экспортыг л аль болохоор нэмэгдүүлэх ийм чиглэлээр л ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууна.

Б.Баттөмөр: Энэ компанийг олон нийтийн болгох чиглэлээр юу хийгдэх вэ Наранцогт дарга аа. Энэ дээр бас

тодорхой хариулт хэлээч. Танай бодлого юу байна. Хоёрдугаарт энэ Дугаржав захирал чинь 50, 60 доллароор худалдах л юм яриад байгаа юм. 2022 оны гаалийн статистикаар 1 тонн нь 74 доллар гэж байгаа юм. Монгол Улсын дундаж гаргасан. Тэгтэл Далианы бирж дээр бол 125 доллар байгаа. Энийг энэ биржээрээ худалдаад энийг ахиулах чиглэлээр юу хийж болох вэ гэсэн ийм асуултад хариулт авах гээд байгаа юм. Хаягдал төмрийн менежментийг яаж хийх юм бэ. Монголчууд энэ арматур хийдэг Хятад эзэдтэй хэдэн хүмүүс аваад л стандартын бус арматур хийгээд л нийлүүлж байгаа шүү дээ. Газар хөдлөлт гээд аюултай ийм эрсдэл үүсэж байна шүү дээ. Тэгээд энэ ер нь Монголын төрийн юунд ямар бодлого явах юм бэ. Хаягдал төмөр менежментийг яах юм бэ. Тэр вагонуудынхаа асуудал чинь бол ойлгомжтой шүү дээ. Улсаас 15 сая доллар авангуутаа тэгээд буцаагаад тэр улсад нь түрээсэлдэг ийм юм гэж байж болохгүй шүү дээ. Энийг.../минут дуусав/

Г.Занданшатар: 84. Дугаржав дарга хариулъя. 84 хариулна. 83. Наранцогт дарга.

Г.Дугаржав: Баттөмөр гишүүний асуултад тодруулж хариулъя. Тэгэхээр компанийн ер нь нэгдлийн компаниуд бол бизнесийн зарчимдаа шилжээд бүгдээрээ ашигтай ажиллах ёстой гэдэг ийм үндсэн зарчим барьж байгаа. Тэгээд компани болгоны онцлогоос хамаараад энэ засаглалын хувьд ямар хэлбэрээр сайжрах вэ гэдэг зүйл яригдана. Мэдээж шаардлагатай бол олон нийтийн болгож, нээлттэй хувьцаа гаргах ийм асуудалд тодорхой компаниуд дээр яригдана. Эхний ээлжид Дархан төмөрлөгийн хувьд бид нар хугацаатай үүрэг, даалгаврынхаа хүрээнд бүтэц, зохион байгуулалтын хувьд хамгийн оновчтой шийдлийг гаргаад, мэдээж хэрэг үйл ажиллагаа алдагдалтай байж маш олон хүнийг ингээд ажиллуулаад байх ийм боломж байхгүй. Тэгэхээр мэдээж засаглал, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын

хувьд эхний ээлжид өөрчлөлт орно. Ингээд цаашидаа бол стратеги төлөвлөлт 5 жилийн, 15 жилийн үндсэн чиглэлийнхээ хүрээнд энэ асуудлуудаа бүгдийг нь цэгцлээд явна.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн алга байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Тэгэхээр сүүлийн үед бас энэ төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг сонсоход ер нь I жишиг тогтчихжээ. Ерөөсөө л энэ чуулган дээр ярьж байгаа зүйл байна шүү дээ. Тэр ерөөсөө л тийм газартай шүүхдэлцэж байгаа, эчнээн төгрөгийн татварын өртэй байгаа, тэр дарга нь төдийн авлига аваад шоронд орсон. Тэр АТГ-д шалгагдаж байгаа. Ерөөсөө хөгжил дэвшил ярихгүй. Тэгээд би эртээд бол энийг зүгээр жишээ болгоод хэлсэн Ерөнхий сайд буруу ойлгосон юм уу эсвэл гуйвуулсан юм уу авлигачдыг өмөөрч дуугарлаа л гэсэн. Та нар Монголын хувийн компаниуд дээр очоод тэр хуралд нь суугаад үзээрэй. Яаж энэ дэлхийн зах зээлд гарах вэ, яаж экспортоо нэмэгдүүлэх вэ, тийм зүйлүүдээ л голлон ярьж байгаа шүү дээ. Тэр жижиг сажиг хулгайн асуудлыг бол тэр хариуцдаг газрууд нь хийгээд л явчихна. Тэгэхээр ийм стратеги зүйл ярих юм нь дандаа л ийм асуудал ярьж байгаа байхгүй юу. Би харамсаж байна. Жишээлэхэд энэ Дүгэржав гэдэг залуу, Наранцогт чадалтай, чадвартай залуучууд өдөржин л нөгөө өр, авлагаа барагдуулах гээд Сангийн яам, нөгөө Эдийн засаг, хөгжлийн яам ингээд л үүд сахиад л та нар хамаг цагаа барж байгаа шүү дээ. Яагаад гэхээр угаасаа жишиг нь буруу байхгүй юу. Хувийн хэвшил ажиллуулдаг юмыг төр авчхаад л, төр өөртөө булуу хурааж байгаа шүү дээ. Төр яагаад ингээд бизнес хийх гээд, яагаад төр ингээд бизнесийн өрсөлдөгч болчихоод төр ингээд чадахгүй юмандаа хошуу дүрээд байдаг юм. Даахгүй нохой булуу хураана гэж. Би энд манай Амарбаясгалан дарга

сууж байна. Залуу хүн хэлмээр байна. Одоо энэ бүх төрийн өмчид авдгаа больчих оо. Харин тэр хувийн хэвшилтэй нь хэлцэл хий. Чи татвар эчнээнийг төлнө шүү, чи тэдэн зуун хүнийг харин ажлын байртай болгоодох. Төр чамд энэ дээр яаж туслах вэ, яаж зөвлөн туслах вэ гээд ингэж хамтарч ажиллаж юмыг хийдэг болохоос зүгээр чадахгүй байна гээд булааж авчхаад өнөөдөр ингээд өөрсдөө ийм хүндрэл яриад сууж болохгүй шүү дээ. Би тэр Пак Жон Хи Солонгосын Ерөнхийлөгч хувийн хэвшлийнхнийгээ дуудаад л яаж туслах вэ. Чи дэлхийд өрсөлдөх усан онгоцны үйлдвэр бариадах гээд л ажиллаж байгаа тийм юмнууд байж л байдаг шүү дээ. Тэгж л ажиллах ёстой шүү дээ. Тэгэхэд чинь өнөөдөр та нар эдийн засгийн энэ бүтцийг аваад үзээрэй. Хувийн хэвшил улам багасаад л байна, багасаад л байна. Тэгээд би тэр нүүрсний нөгөө түр хороонд байдаг. Үгүй ээ, төрийн өмчит компани дээр л энэ хулгай, зэлгий энэ аймаар юм чинь байна шүү дээ. Авлига чинь байна. Тэгэхээр энэ бүх юмаа ер нь зогсоож болдоггүй юм уу. Үгүй ээ, тэр хэдэн хувийн хэшилдээ л дэмжээд л өгчих л дөө. Хувийн хэвшил нь баяжчихна гэхээс юундаа тэгтлээ их айгаад байдаг юм бэ. Хувийн хэвшил чинь баяжихаараа татвар төлдөг юм. Хувийн хэвшил чинь баяжихаараа ажлын байр бий болгодог юм. Үгүй ээ, тэгээд л яв л даа. Тэгэхгүй тэгээд л ерөөсөө л бүх юмыг төр хийнэ гэдэг нэг ийм юм болчихоод байна.

Та нарын бас нэг жишээ бол Хөтөл байна. Ийм Монгол бизнесийн орчин муудчихсан үед яаж Хөтлийнхөн тэр чинь ашигтай ажиллах юм. Тэгэнгүүт хувийн хэвилээс булааж аваад л төр хийж байгаа юм. Хувийн хэвшил чинь алдагдалтай үедээ ашигтай салбараасаа авч нөхдөг. Өөрсдийнхөө гэр орныг ч гэсэн барьцаанд тавьж байгаа зээл аваад ингээд.../минут дуусах/

Г.Занданшатар: Наранцогт дарга 83.

С.Наранцогт: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг таны хэлж байгаа стратеги зарчмын асуудал бас Засгийн газар, манай хувьцаа эзэмшигч Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр нэлээд яригдаад ер нь Засгийн газар энэ төрийн өмчит компаниуд өмнө нь бол нөгөө бизнесийн үйл ажиллагаанд нэлээн оролцдог байсан байна. Бизнес төсөл хэрэгжүүлэх үүрэг, даалгавар өгдөг байсан байна. Үүнээс болж нэлээдгүй бас асуудлууд юмнууд их орсон байна. Томилгоо юманд оролцдог байсан гээд. Тэгээд одоо энэ сая 3 сард гарсан нэгдлийн дүрэм Засгийн газар баталж өгөхдөө үндсэн гол зарчим энэ үүсээд байгаа тулгамдсан гол зарчмын асуудлаа үүнд тавьсан. Өөрөөр хэлэх юм бол засаглалыг яг энэ бизнесийн маш туршилагатай олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ийм нэр хүндтэй хувийн хэвшлийн хүмүүсийг түлхүү оруулж ирж ТУЗ нь гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагааны хамтын хариуцлага тооцдог ийм тогтолцоонд орох гээд ингээд хараат бус гишүүдийнх нь болоод хараат гишүүдийнх нь сонгон шалгаруулалтын зар гараад ингээд явж байгаа. Энэ дээр маш тодорхой энэ шаардлагуудаа тавиад өгсөн. Тэгээд энэнээс хойш бол Засгийн газар үндсэндээ л ерөөсөө энэ компаниудын ноогдол ашиг, үр ашиг энэтэй л асуудал ярья. Энийгээ нэмэгдүүлэх ийм зарчмын шаардлага тавихаас биш компанийн бизнесийн шийдвэр, бизнес үйл ажиллагаанд ерөөсөө оролцдог зүйлийг больё гэдэг ийм зарчмын шийдэл гарч байгаа нь бол бас засаглалыг сайжруулах чиглэл рүү явж байгаа. Тэгээд цаашидаа ч гэсэн түрүүн Баттөмөр гишүүний ярьж байгаа энэ компанийг нээлттэй болгох, нэмэлт хувьцаа гаргах иймэрхүү асуудал бол бас цэвэр бизнесийн стратегийн өөрийнх нь шийдвэр учраас энийг бол цэвэр ТУЗ, компанийн засаглал өөрөө шийдээд ингээд явдаг байхгүй бол энэ дээр нөгөө Засгийн газар юм уу аль нэгэн газраас ийм үнэгүй хувьцаа эзэмшүүлэх ч гэдэг юм уу иймэрхүү асуудал гарах нь өөрөө энэ төрийн өмчит компаниуд бизнесийн

зарчмаар үйл ажиллагаа явуулахад их хүндрэлтэй асуудал үүсэж байна гэсэн ийм дүгнэлт гараад энэ чиглэл рүүгээ ажлууд бол хийгдээд явж байгаа юм. Энэ нь бол засаглалын үйл ажиллагаа. Тэгэхээр бол бид нар таны хэлж байгаа шиг энэ манай ТУЗ-д бол ер нь бизнесийн, хувийн хэвшлийн, нэлээн туршилагатай ийм нэр хүндтэй менежерүүд манай толгой компанийн болоод энэ группийн ТУЗ-үүдэд орж ирж ажиллах ийм нөхцөл бүрдэж байгаа. Нэлээн тоо хэмжээгээр. Ингэхлээр бол бизнес шийдвэрүүд бол цэвэр бизнесийн зарчмаар манай хувийн хэвшлийнхний экспорт, бизнес туршилагатай хүмүүс шийдвэр гаргахад оролцож явдаг ийм тогтолцоог бид нар бүрдүүлж байна. Энэ дүрмийн өөрчлөлт бол Засгийн газраар батлагдаад албажиж байна.

Доошоо нэгдэлд харьяалагдах бүх компаниуд дээр нэгэн адил нэг загварын дүрмээр ажиллахаар болж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл цаашидаа бол бизнесийн дотоод үйл ажиллагаа, бизнес шийдвэр, гүйцэтгэх захирлын томилгоонд хүртэл бол ТУЗ өөрөө гүйцэтгэх захирлаа сонгон шалгаруулж, томилоод, тэгээд энэ гүйцэтгэх захирлын компанийн үйл ажиллагааны үр дүнгийн хариуцлагыг ТУЗ хамтдаа хүлээнэ гэдэг ийм зарчмын өөрчлөлт орно. Энэ юу гэсэн үг вэ гэхлээр цаашидаа энэ Засгийн газраас төрийн өмчит компаниудын дотоод бизнес үйл ажиллагаанд оролцох явдал бол нэлээд хязгаарлагдаад явчхаж байгаа юм. Тэгэхээр үүний хүрээнд бол засаглал үйл ажиллагаа бол нэлээн сайжирна.

Бизнесийн үйл ажиллагааны үр ашиг гэдэг бол зайлшгүй манай үндсэн чиглэл стратеги төлөвлөлтдөө мэдээж энэ улсуудын оролцоог хангаж байж бид нар эцэслэн хувийн хэвшлийн энэ туршилагатай сайн менежерүүд экспортуудыг оролцуулчих замаар эцэслэн батална гэж ингэж бодож байгаа. Ер нь драфтаа хийгээд явж байгаа. Тэгэхээр бол бид нар нэгдлийн

хэмжээний компаниудын хувьд бол нэлээд сайн стратеги яг бизнесийн зарчим дээр тулгуурласан стратеги төлөвлөгөө, үндсэн чиглэл гараад ирэхээр бол үйл ажиллагааны хувьд бол эрс сайжирна гэсэн хүлээлттэй байгаа. Мэдээж хэрэг таны ярьж байгаа шиг энэ олон жилийн бас нэлээдгүй хуримтлагдсан асуудлууд бол бүх компани дээр байна. Хуримтлагдсан өр төлбөрийн асуудал ч байна. Яг энэ дархан төмөрлөгийн хувьд тухайлан ярих юм бид.../минут дуусав/

Г.Занданишатар: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Даишэвэгийн Амарбаясгалан дарга хариулна. Нэмж хариулна. 91.

Д.Амарбаясгалан: Одонтуяа гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Санал нэг байгаа юм. Төр энэ бизнесийн үйл ажиллагаанаас аль болох богино хугацаанд татгалзах нь ерөөсөө энэ Засгийн газрын гол стратеги болоод ажиллаж байгаа гэдгийг бас юун түрүүнд хэлье. Сая Наранцогт дарга дэлгэрэнгүй тайлбарлалаа. Өнөөдрийн байдлаар төрийн өмчит үйлдвэрийн газар статустай хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани зэрэг нийлээд төрд 119 компани байна. Нийслэлд 107 байна. Дүүргүүдэд 22 байна. Тэгээд Засгийн газар энэ онд эдгээр төрийн өмчтэй үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг үйл аж ажиллагааных нь чиглэлээр нэгтгэж цөөлөх бодлогыг нэгдүгээрт баримтална.

Хоёрдугаарт зайлиггүй төрд байх шаардлагагүй өмчит компаниудыг татан буулгах ажлыг бас богино хугацаанд зохион байгуулна гэсэн ийм дүр зурагтайгаар ажиллаж байна. Бидний тооцоолж ажиллаж байгаагаар 30-40 хувиар тоог нь цөөрүүлэх бодлогыг эхний ээлжид авч хэрэгжүүлнэ. Үүний хажуугаар мэдээж засаглалыг сайжруулах, ТУЗ-ийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог байх,

цаашилаад гүйцэтгэх захирлыг олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулах зэрэг ажлыг эрчимтэй явуулах нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа юм. Үүний цаана юу байгаад байгаа юм гэхээр Монголын төр жилдээ 12 орчим их наяд төгрөгийн худалдан авалтыг хийж байгаагийн 7 орчим нь өөрөө энэ төрийн өмчит компаниудын үйлдвэрлэж байгаа байдалтай шууд холбогдоод байгаа учраас л энийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг хийнэ.

2 дахь зүйл нь өнгөрсөн жил Улсын Их Хурлаар батлагдсан тогтоолын дагуу нээлттэй компани болгох төрийн өмчит компаниудын жагсаалт гарсан. Үүний дагуу Төрийн банк, Хөрөнгийн бирж зэрэг байгууллагуудыг IPO хийх ажил амжилттай хийгдсэн. Цаашилаад АЗЗА, Давхар даатгал зэрэг компаниудыг IPO хийх ажил ид судлагдаж явж байна. Харамсалтай нь Улсын Их Хурлаас гарсан тогтоолыг яг хэрэгжүүлэхэд амьдрал дээр очоод үүсэж байгаа хүндрэлүүд бас олон талтай байна. Жишээлбэл 21 АЗЗА-г тус бүр нээлттэй компани болгоё гэхээр 1 бүрийн өртөг нь 1 орчим тэрбум төгрөгийн өртөгтэй. Нөгөөдхийг яг хувьчлал IPO хийх үйл ажиллагаа явуулахад сонирхож худалдан авах хүсэлтэй байгаа хувийн хэвшил төдийлөн гарч ирэхгүй байна. Тэгэхээр Засгийн газраас бол Улсын Их Хуралд тогтоол өргөн барих гэж байгаа нь эдгээр АЗЗА-г нэгтгэж 1 үндэсний хэмжээний компани болгох, үнэлгээ өгсний үндсэн дээр хувийн хэвшлийн сонирхлыг татах боломжийг бүрдүүлээд, IPO хийе. Энийг бүүр цаашилаад заавал 34 хувиар хязгаарлагдахгүй, 51, 49 бүр 66 хувийг нь хүртэл хувийн хэвшилдээ аваачих энэ бодлогыг Засгийн газраас бариад ажиллаж гэж байгаа юм. Тэгээд энэ мэтчилэнгээр Улсын Их Хурлынхаа дэмжлэгтэйгээр Засгийн газар энэ ондоо энэ ажлыг амжилттай хийж хэрэгжүүлнэ.

2 дахь зүйл нь бол энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хөтлийн цементийг мэдээж төр хийсэн байсан концесс болон хувьчлалынхаа гэрээг цуцалсан үйлдэл болсныг бас сайн ойлгож авах нь хэрэгтэй байх. Түүнээс хувийн хэвшилд зүгээр үйл ажиллагаагаа явуулж байсан хувийн хэвшлийн компаниудыг төр хураагаад авчихсан зүйл огтоос биш юм шүү гэдгийг сайтар ойлгомоор байгаа юм. Төртэй байгуулсан концессынхоо гэрээнд хүрч чадаагүй, хувьчилж авсан үйл ажиллагаа зорилго, чиглэлээ бүрэн хангаж чадаагүй байгаа юм. Дарханы төмөрлөгийн үйлдвэр жишээ нь гангийн үйлдвэр байгуулах зорилготой концессоор авчхаад өнөөдрийг хүртэл ган үйлдвэрлэж чадаагүй. Гангийн үйлдвэрлэл бүр зогсоод, зөвхөн зэсийн баяжмалыг зарж борлуулдаг трейдингийн компани болтлоо өөрчлөгдчихөж байгаа юм. Хөтлийн цементийн үйлдвэр ч гэсэн мөн адил. Ерөөсөө зах зээл дээр хиймэл хомсдолыг үүсгэж цементийн үнэд хүргэж зардаг зориулалттай тийм л компани болж хувирсан. Тэгэхээр энийг төр нэгдүгээрт гэрээгээ цуцалъя. Хоёрдугаарт энэ шүүхийнх нь асуудлыг богино хугацаанд шийдвэрлээд, богино хугацаанд олон нийтийн нээлттэй компани болгох ажлыг зохион байгуулъя. Нөгөө талаасаа хувьчилж авч байгаа, хувьчлалд оролцож байгаа хувийн аж ахуй нэгжүүд минь бас хариуцлагатай байх ёстой шүү гэдэг энэ зарчмын шаардлагыг Засгийн газраас тавьж ажиллаж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Төрийн оролцоотой холбоотой асуултыг асуух гэж байсан сая Амарбаясгалан дарга бас ихэнх хариултыг нь өгчихлөө дөө. Яах вэ өнөөдрийн нөхцөл байдлаар харахаар эдийн засагт төрийн оролцож байгаа төсвийн хуулиар төрийн өмчит компаниуд, тусгай зориулалттай зээлийн

сан гээд ингээд ангилах юм бол ойролцоогоор бараг 80 хувь руу дөхсөн байдалтай байна. Тэгээд төсвийн алдагдлаар эргээгээд дандаа зээл бонд, эд нараа санхүүжүүлээд, үндсэндээ бид нар урд хормойгоо хойд хормойгоор нөхөөд явж байгаа нөхцөл байдал бас байна. Яах вэ сүүлийн 3 жил бол Засгийн газар бол яг энэ авлигатай тэмцэх, хөсрийг нь цэвэрлэх ажлыг бол нэлээн тууштай явж хийж ирлээ. Гэхдээ цаашидаа бол хийх ажлууд бас нэлээн байна. Энэ 80 хувийг яаж ингээд хувийн хэвшил нь 80 хувь дээр авчрах вэ. Төрийн оролцоог яаж 20 хувь дээр авчрах вэ гэдэг л ажлыг бид нар хамтдаа хийхгүй бол болохгүй байна гэж байгаа юм. Засгийн газрын тусгай зориулалтын сан гээд 25 сан байна. Ойролцоогоор 2 их наяд төгрөг энэ сайд нарын хармагаар ерөөсөө дамжаад л өөрийн хармааны аж ахуйн нэгжүүддээ тараадаг ийм сангууд байна. Тэгээд нөгөө сан бол яах вэ эхний үедээ байгуулахад бол их л тийм зорилго тавиад л, гоё зорилго тавиад л байгуулдаг. Тэгээд явцын дунд болохоор яг тэр салбар дээр шударга өрсөлдөөнийг байхгүй болгож байдаг. Тэгэхээр энийг цаашидаа ер нь хэрвээ ямар нэгэн байдлаар сан байгуулахаар бол хугацаатай болгомоор юм байна лээ. Яг ийм зорилготой, хэрэгжих зорилттой, тэгээд зорилтоо хэрэгжсэн бол татан буугддаг байх. Татварын хөнгөлөлт ч гэсэн ялгаагүй. Татварын хөнгөлөлт өгвөл зорилттой, хугацаатай тэгээд эргээгээд татвараа авдаг байх. Энэ дээр бас яагаад энийг яриад гэхээр цемент болон бусад төрлийн импортын татвар гээд бид нар дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ гээд татварыг нь өндөр болгочихдог. Гэхдээ яг эцсийн хохирч байгаа хүн нь хэн байдаг вэ гэхээр дандаа хэрэглэгч байдаг. Бид нар импортыг орлуулах бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэж байвал өрсөлдөх чадвартай байх ёстой. Тэрнээс биш зах зээлийг нь хамгаалж өгөөд яваад байхаар манайх нэгдүгээрт тэр үйлдвэрлэлүүд чинь ч хөгжихгүй байна. Хоёрдугаарт энэ төсвийн буюу яг энэ татвар төлөгчдийн

хармаанаас энэ мөнгө нь гарч яваад байгаа юм. Одоо яах вэ яг энэ зорилтын хүрээнд бол яах вэ сангуудаас гадна энэ төрийн өмчит компаниудын асуудлууд бол тодорхой хэмжээг нь олон нийтийн нээлттэй хувьцаат компани болох ажлууд бол хийгдээд явж байна. Тогтоол гарч байгаа. Шинээр төрийн өмчит компани байгуулахгүй байх тал дээр Улсын Их Хурлын бас тогтоол бэлтгэгдээд явж байна. Тэгээд энэ Дарханы захирлын яриаг би нэлээн сайн сонслоо л доо. Тэгээд асуудал нь юу юм гэхээр өмнөх энэ асуудлуудаа яриад байна л даа. Тэгээд энэ гишүүдийн бас бухимдаад байгаа асуудал цаашидаа яах гэж байгаа юм бэ гэдэг асуудалд бас харьцангуй сайн.../минут дуусав/

Г.Занданишатар: Хассуурийн
Ганхуяг гишүүн нэмэлт 1 минут.

Х.Ганхуяг: 1 асуулт байна. 1 дүгээр асуулт юу вэ гэхээр цаашидаа ер нь ямар хэмжээний төсөвт энэ татвар төвлөрүүлдэг байх юм. Хэзээ олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох юм. Ядаж тэр Дарханд ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс нь энд хувьцаа эзэмшдэг болох.

Гуравдугаарт энэ дотоодынхоо арматур хэрэгцээг ер нь хэзээ яг хангадаг болох вэ. Одоо яг энэ Монголын тэр баялаг бүтээгч нарт бол хамгийн чухал асуудал бол арматур байгаа байхгүй юу. Тэгээд одоо бид нар импортлон хэвээрээ л байна. Тэгсэн мөртөө импортын татвар өндөр байдаг. Тэгсэн мөртөө би тэр гадаадын зээл тусламжаар танай дээр үйлдвэр бариулчихсан байдаг. Тэгээд тэрийгээ ашигладаггүй. Тэгээд энэ арматуртай холбоотой асуулт дээр л хариулт авъя.

Г.Занданишатар: Дугаржав. 83.

Г.Дугаржав: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Цаашидаа яах вэ гээд. Цаашидаа бол бид түрүүнд бас дурдсан Алсын хараа 2050, шинэ сэргэлтийн

бодлого, хөтөлбөрүүдэд орсон “Монгол ган” цогцолбор гэдэг цогцолбор аж үйлдвэрийн паркийн хэмжээний байгууламж, бүтээн байгуулалтыг хийх ёстой. Үүгээр бол бид жилд 350,000 тонн гангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ийм хүчин чадлыг шинээр үүсгэнэ ээ. Одоо манай үйлдвэр бол зөвхөн хаягдал төмөр боловсруулах ийм анхнаасаа зориулалттай, ийм хүчин чадалтай суурилагдсан хүчин чадалтай ийм гангийн үйлдвэр байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар бид нар 11 мянган тонн арматур үйлдвэрлэж байна. Импорт бол 2022 онд 343.4 мянган тонн яг арматур нь өөрөө орж ирсэн гэсэн ийм гаалийн мэдээ байна. Энэ бол хамгийн өндөр тоо байгаа. 2022 онд. 2021 онд 260, 2020 онд 238 мянган тонн арматурууд тус тус импортлогдож байжээ. Ингээд “Монгол ган” цогцолборыг барьж байгуулснаар бид нар ямар ч байсан импортын арматурын 50 хувийг орлоно, импортыг орлоно гэсэн ийм зорилт дэвшүүлж ажиллаж байгаа. Энэ хүрээнд бол манай төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг бид нар хувьцаа эзэмшигч компанитайгаа, Засгийн газартай бол ярилцаж байгаад бүрдүүлнэ. Нийт 508 сая америк долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй. 5 цогцолбор үйлдвэрийн ийм сет аж үйлдвэрийн байгууламж болох юм.

Олон нийтийн болох асуудлаар хэзээ болох вэ гэхээр энэ стратеги менежментийн асуудал учраас би толгой компанийн захирлыг буюу хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг хариулаасай гэж хүсэж байна. Ийм л бид нар өмнөө тавьсан зорилтуудтай ажиллаж байгаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэлнэ. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: 1990 онд Японы ард түмний хөрөнгөөр байгуулагдаж, 1994 онд ашиглалтад орсон. 240 сая тонны нөөцтэй ордтой. 100,000 тонн цувимал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орсон. Ашиглалтад орсон өдрөөс эхлээд зарим хүмүүсийн арааны шүлс нь асгарч эхэлсэн л дээ. Янз бүрийн захирлууд томилогдсон, мэргэжлийн бус, хулгай дээрэм өнгөрсөн хугацаанд зөндөө явсан. Ашигт малтмалын лицензийг нь хүртэл хувь хүмүүс авчихсан байсан. Буцааж авсан. Ийм л юм болсон л даа. Тэгээд 2011 оноос эхлээд энийг авах бизнес улс төрийн бүлэглэлүүд арга зохиож эхэлсэн. 2010-2011 онд Хөрөнгө оруулалтын гэрээ гэдэг хуурамч цаас үйлдвэрлэсэн. 2013 онд концессын жагсаалтад оруулсан. 2014 онд концессын гэрээ нэртэй ийм луйврын цаас бас үйлдвэрлэсэн байдаг. 2014 онд Монгол Улсын Засгийн газар Монголд ганцхан байдаг энэ “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийг концессын гэрээгээр өгөх шийдвэр гаргаад, тэгээд тендер зарласан байгаа юм. Энэ тендерт Солонгосын Поско, Энэтхэгийн Миско Стил, Ай Си Эм БНХАУ-ын Боуган, Хятадын машин үйлдвэрийн корпорац гээд дэлхийн алдартай 5 компани энэ тендерт ороод Монголд бүртгэгдээд 2 жил болсон нь үйл ажиллагаа явуулаагүй “Кю Эс Си” гэдэг компанид энэ 5 компани навс ялагдчихсан байдаг байхгүй юу. Яг энэ үеэс эхлээд л ингээд л луйвар эхэлсэн л дээ. Яагаад луйвар гэж байна гэхээр ерөөсөө 1.3 их наяд төгрөгийн хохирол учирсан байгаа. 100.2 тэрбум төгрөг нь “Кю Эс Си”-ийн менежментийн төлбөр гэж гэрээнд байхгүй. 108.3 төгрөг нь ханишийн тэгшитгэл. 56.5 сая доллар нь ямар үйлчилгээнд төлөх нь тодорхойгүй. 154 тэрбум төгрөг нь урьдчилж төлсөн зардлаар бүртгэгдсэн менежментийн төлбөр гэх мэтээр ингээд Дарханы

төмөрлөгийн үйлдвэрээр санхүүжүүлчихсэн. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн нэрээр Кю Эс Си зээл аваад өөрснөө авчихсан. 314 тэрбум төгрөг. Гаалийн байгууллагын үнэлгээгээр 679 сая долларын бараа, бүтээгдэхүүнийг 373 гээд 1 дахин бага үнээр үнэлээд 840 тэрбум төгрөгийн хохирол учирчихсан. Гэрээний хэрэгжилт хангалтгүй. Хуурай, нойтон баяжуулах үйлдвэр бай байгуулна гэсэн байхгүй. Цахилгаан дамжуулах шугамыг өөрийн хөрөнгөөр барина гэсэн төсвөөс мөнгийг нь гаргаж хийсэн. 33.4 километр замыг барина, ашиглана, шилжүүлнэ гэсэн бол 183 тэрбум төгрөгийг төсвөөс авчихсан. 95 километр авто замыг бас төсвөөс. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хүчин чадлыг 300,000 тонн болгон өргөтгөнө гэсэн хэрэгжээгүй. Ингээд л 1 төрийг төгс тоносон ийм хулгай байхгүй юу. Энэ нөгөө эзэнгүй төрийн эмгэнэл гэдэг бол яг энэ байгаа. Үнэхээр харамсалтай байгаа байхгүй юу. Ингээд энэ төрд авсан. 2 захирлын нүүр үзээд явж байгаа. Дугаржав бол сайн ажиллах ёстой. Хэрвээ муу ажиллах юм бол би Дарханаас сонгогдсон гишүүний хувьд бол зүгээр суухгүй шүү. Өөрчлүүлэх санал тавина. Энд олон асуудлууд 100,000 тонны цувимлын үйлдвэрийн 25-хан хувийг нь ашиглаж байгаа шүү дээ. Тэгсэн мөртөө асар их хэмжээний баялаг нөгөө хүдэр олборлоод гараад байдаг. 1650 хүний орон тоотой, үүнээс 280 хүн нь сул зогсож байгаа гэх мэтийн асар их олон ийм асуудлууд энд цугларчихсан байгаа байхгүй юу. Тэгээд эндээс юу гэхээр тэр “Монгол ган” цогцолбор хөтөлбөрөө хэрэгжүүлэх ёстой. Монгол Улсын төмрийн хэрэгцээ 700,000 тонн л байгаа шүү дээ. Энийг 350 тонныг нь хангах тийм үйлдвэр байгуулна гээд, энийгээ барих ёстой.

Төр муу менежер гэдэг юм яриад байгаа. Төр муу менежер биш. Төрөөс томилолт авч явж байгаа хүмүүс ажиллаж чадахгүй байгаа шүү дээ. Улсад төлөөгүй татвар нь 122 тэрбум төгрөг. Орон нутагт төлөх нь бас 1.4

тэрбум төгрөг. Өдөр болгон асуудал болж байгаа гэх мэтийн маш их олон асуудлууд энд хуримтлагдсан байгаа. Ойрын хугацаанд шийдэх ёстой асуудал дээр 3 сая тонн хүдрийн баяжмалыг тээх вагоны асуудлыг “Эрдэнэс Монгол” компани шийдэх ёстой. Яам нь шийддэг юм уу, Засгийн газар нь шийддэг юм уу. Энийгээ шийдэх ёстой. Тэгээд цаашаага тэр цахилгаан хангамжийн асуудлуудыг нь шийдэх ийм шаардлагатай Хаягдал төмрийн тэр менежментийн асуудлыг шийдэх ийм шаардлагатай. Энийг Хөрөнгийн биржээр дамжуулаад худалдах, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж худалдах чиглэлийг эрхэм болгож ингэж ажиллах ёстой. Олон нийтийн болгох хэрэгтэй энэ компанийг. Үйлдвэрлэл, олборлолт, борлуулалтыг нэмэх бүтээмжийг нэмэх замаар энэ ажилчдын цалин, нийгмийн хамгааллын асуудлуудыг нь шийдэх маш их олон асуудлууд тулгарчихсан байгаа. Энийг .../минут дуусав/

Г.Занданшатар: Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэллээ. Дугаржав дарга аа, танд сануулж хэлэхэд сахил хүртээд шал дордов гэгч болов гэдгийг л сануулж байна шүү дээ. Төрд оччихсон юм хяналтгүй байдаг гэдэг юмыг л харуулж болохгүй, төр муу менежер гэдгийг харуулж болохгүй. Сайн ажиллах ёстой. Аливаа ашиг сонирхол хувийн сонирхолд орчихсон асуудалд холбогдож болохгүй. Сайн ажиллана шүү гэдгийг тойргоос сонгогдсон гишүүд Баттөмөр гишүүн, Дамдинням гишүүн 2 онцгой анхааруулж хэлээд байна шүү дээ. Сайн санаж ажиллаарай. Түрүүч, түрүүчийн гашуун туршлага юу дагуулж байгааг та бүхэн харж байгаа биз.

15.11 цаг.

Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ